



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“Орон нутгийн өмчит ХХК-уудын худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн”



Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлаагүй байна.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....
Дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа	Бүлэг 1. Худалдан авах ажиллагаанд хуулийн заалтыг мөрдөөгүй, үр ашигтай ажиллаагүй байна.
Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг	1.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөж, зохион байгуулаагүй байна..... 7-9
Ахлах аудитор Ц.Лүндэгмаа Аудитор П.Энхбаяр	1.2.Компаниуд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.....9-16
2019 оны 6 дугаар сар	Бүлэг 2. Худалдан авах ажиллагаанд шат шатны хяналт дутагдаж байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу	2.1. Компанийн худалдан авах ажиллагаанд тавих хяналт дутагдаж байна.....16-28
ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр	2.2. Худалдан авах ажиллагаанаас бий болсон ашиг, алдагдлыг тооцож тайлагнаагүй байна.....29-33
	Аудитын дүгнэлт.....34-35
	Аудитын зөвлөмж.....36
	Холбогдох байгууллагын санал.....37-40
	Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар.....41

Товчилсон үгийн жагсаалт

ОНӨ ХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
МУ	Монгол улс
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
НААҮ	Нийтийн аж ахуй үйлчилгээ
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХК	Хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
МССТ	Музей сургалт судалгааны төв
ЭЭС	Эм эргэлтийн сан
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
ХАА	Худалдан авах ажиллагаа
НҮГ	Нийтлэг үйлчилгээний газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨГАҮ	Төрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээ
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн өмчит ХХК-уудын худалдан авах ажиллагааны үр дүн”сэдэвт гүйцэтгэлийн аудит хийв.

Аудитын зорилт:

“Орон нутгийн өмчит ХХК-уудын худалдан авах ажиллагааны үр дүн” сэдэвт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ.

1. Худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулж чадсан эсэх;
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулснаар компанийн санхүүгийн чадавх дээшилсэн эсэх

Хамарсан хүрээ:

Тус аудитад Чандмань-Илч ОНӨ ХХК, Чандмань бадрал ОНӨ ХХК, Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК, Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ, Эм эргэлтийн сан ААТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар гэсэн 6 байгууллага, тэдгээрийн Төлөөлөн удирдах зөвлөлүүдийг хамрууллаа.

Аргазүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, санхүүгийн албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, судлах, дүн шинжилгээ болон харьцуулалт хийх, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмжийг өглөө.

Орон нутгийн өмчит ХХК, ААТҮГ-ын тухай товч мэдээлэл.

Чандмань-Илч ОНӨ ХХК: Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 28 дугаар тогтоолоор компанийн дүрмийг баталсан байна. Компани нь 100 хувь орон нутгийн өмч байх бөгөөд түүнийг захиран зарцуулах эрх, үйл ажиллагаа нь Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.

Тус компанийн дүрэмд Дорноговь аймгийн харьяа сумдын оршин суугчдыг дулааны эрчим хүч, цэвэр усаар хангах, бохир ус зайлуулах үндсэн үйл ажиллагааг явуулахтай холбоотой төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрийг биелүүлэх зорилготой ашгийн төлөө хуулийн этгээд мөн гэж тодорхойлсон байна. Мөн компанийн өмчлөгч нь аймгийн ИТХ байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь аймгийн Засаг дарга, орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч нь ТУЗ байна гэжээ.

Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Чандмань бадрал ОНӨ ХХК: Аймгийн ИТХ-ын 2013 оны 4/07 дугаар тогтоолын дагуу Чандмань-Илч ХХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулан охин компанийн дүрмийг батлуулах тухай Чандмань-Илч ХХК-ийн ТУЗ тогтоол гаргасан байна. Аймгийн Засаг даргын 2014 оны А/96 дугаар захирамжаар Чандмань-Илч ХХК-ийн дүрэмд орсон өөрчлөлт, охин компани Чандмань бадрал ХХК-ийн дүрмийг тус тус баталсан байна.

Чандмань бадрал ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 5 дугаар тогтоолоор Чандмань-Илч ХХК-ийн охин кампани болох Чандмань бадрал ХХК-ийг бие даан үйл ажиллагаа явуулахаар болсон бөгөөд сумын ИТХ-ын 2017 оны 04/05 дугаар тогтоолоор орон нутгийн өмч болох Чандмань бадрал ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр Замын-Үүд сумын Засаг даргыг томилсон байна.

Замын-Үүд сумын Засаг даргын А/58 дугаар захирамжаар Чандмань бадрал ХХК-ийн дүрмийг баталжээ.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК: Аймгийн Засаг даргын 2004 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 27 дугаар захирамжаар Төхижилт ОНӨҮГ-ыг Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК болгон өөрчилж компанийн дүрмийг баталсан байна. Компанийн эд хөрөнгө нь 100 хувь орон нутгийн өмч байна гэж тодорхойлжээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ: Эрдэнэ сумын ИТХ-аас 2009 оны 11 сарын 11-ний өдрийн 40 дугаар тогтоолоор баталсан Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ-ын дүрэмд Эрдэнэ сумын орон нутгийн өмч дээр тулгуурласан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэж тодорхойлсон ба төрөөс олгосон өмчид тулгуурлан иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэн ашиг орлогоо нэмэгдүүлнэ гэж заасан байна.

Сумын ИТХ-ын 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 15/03 дугаар тогтоолоор Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулсан байна.

Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 98 дугаар тогтоолоор НҮБ-ын Хүүхдийн сан, Эрүүл мэндийн яамны хамтарсан “Хамт олон-Эрүүл мэнд” төсөл хэрэгжсэний материаллаг бааз дээр түшиглэн “Эм эргэлтийн сан” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулахаар тогтоосон байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 10 дугаар захирамжаар “Эм эргэлтийн сан” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм, бүтэц, орон тоог баталсан байна.

Тус байгууллага нь орон нутгийн иргэд, эрүүл мэндийн байгууллагыг МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдсэн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үндсэн үйл ажиллагаа явуулах бөгөөд төрийн бодлого, хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэх зорилготой ашгийн төлөө хуулийн этгээд мөн гэж дүрэмдээ заасан байна.

Нийтлэг үйлчилгээний газар: Аймгийн Засаг даргын 2001 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 196 дугаар захирамжаар “Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Нийтлэг үйлчилгээний газар”-ыг байгуулсан байна.

Тус байгууллагын дүрэмд 3 удаа өөрчлөлт оруулсан ба анхны дүрэмд “аймгийн Засаг дарга түүний Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон төсвөөс санхүүждэг төр засгийн бусад байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн ажлыг эрхлэн, тэдгээрийн хөрөнгө санхүүгийн нийтлэг нөөцийг уялдуулан зохицуулах үүрэг бүхий нутгийн захиргааны хэрэгжүүлэгч чиг үүрэг бүхий **төрийн үйлчилгээний байгууллага мөн**” гэж тодорхойлсон бол 2017 онд дүрэмд өөрчлөлт оруулж “... аймгийн Засаг дарга түүний Тамгын газар болон төсвөөс санхүүждэг бусад байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, нийтлэг үйлчилгээний талаар тогтоосон нэгдсэн бодлогыг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий нутгийн захиргааны хэрэгжүүлэгч **Орон нутгийн төсөвт албан газар мөн**” гэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн захирамжаар шинэчлэгдэн батлагдсан дүрэмд “аймгийн Засаг дарга, ИТХ-аас бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь үйлчилгээ, аж ахуйн ажлыг хэрэгжүүлэх, байгууллагын өөрийн орлогод тулгуурлан үйл ажиллагаа эрхлэх, **Орон нутгийн өмчит албан газар мөн**” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулиар аймаг, сумын төсвийн татварын бус орлогын бүрдүүлэлтэд орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг орохоор заасан хэдий ч аудитад хамрагдаж байгаа байгууллагуудын дүрэмд энэ талаар тусгагдаагүй байна.

Бүлэг 1

**Худалдан авах ажиллагаанд хуулийн заалтыг мөрдөөгүй,
үр ашигтай ажиллаагүй байна.**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөж, зохион байгуулаагүй байна.

1.1 Ихэнх орон нутгийн өмчит байгууллага тендерт оролцохдоо ТАХ-ний үр ашгийн тооцоо гаргаагүй байна.

Чандмань-Илч ОНӨ ХХК улсын болон орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 2.1 тэрбум төгрөгийн 4 ажилд гүйцэтгэгчээр шалгарч, гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгэж, 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан байна. ХАА-нд оролцохдоо 0.5 тэрбум төгрөгийн үр ашиг бий болохоор тооцоолжээ.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК сумын орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх 159.0 сая төгрөгийн 13 ажилд оролцохдоо үр ашгийн тооцоо гаргаагүй байна.

Чандмань-Бадрал ОНӨ ХХК орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх 582.1 сая төгрөгийн 4 ажилд оролцохдоо үр ашгийн тооцоо гаргаж ажиллаагүй байна.

Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ, Нийтлэг үйлчилгээний газар, Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ, Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ зэрэг ААНБ улсын болон орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгөөр санхүүжүүлэх ХАА-нд оролцоогүй байна.

1.2 Худалдан авах ажиллагааг төлөвлөж батлуулаагүй байна.

МУ-ын Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам-ын 2.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн харьяа төсөвт бүх байгууллага, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын тухайн онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг нэгтгэн журмын 2.4-т заасны дагуу баталж, тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсвийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заажээ. Гэтэл аймгийн 2018 оны ХАА-ны төлөвлөгөөнд орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын тухайн онд худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөө тусгагдаагүй байна.

Журмын 2.6-д “Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид “захиалагч” гэх/-ийн тухайн онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг нэгтгэж журмын 2.4-т заасны дагуу баталж, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлагдсан төсөв /зорилтот түвшин/-ийн

хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Компанийн тухай хуулийн 3.5-д “Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ” мөн 16.1-д “Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг мөн” гэж заажээ.

Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит ААНБ-уудын дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг ИТХ-аар батлуулсан байна.

Чандмань-Илч ХХК-ний дүрмийн 6.6-д “Гүйцэтгэх захирал компанийн үйлдвэрлэл, төсөв төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах, тайлагнах эрх үүрэгтэй”, хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам боловсруулж батлуулах гэж заасан. Гэтэл АИТХТ-ийн 2016 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан уг дүрэмд 2019 оны 30 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулахдаа дээрх заалтуудыг хасаж батлуулсан байна. Энэ нь тус компанийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагаа төлөвлөсөн зорилтгүй, хөрөнгө санхүү хяналтгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж, Компанийн тухай хуулийн заалтыг¹ зөрчихөд хүргэж байна.

Цаашид компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх төслийг хуулийн дагуу хэлэлцэн баталж, улсын бүртгэлд² бүртгүүлэх нь зүйтэй

Компанийн тухай хуулийн 78.2-д “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ” гэж заасан.

Гэтэл ТУЗ-ийн дарга нар хурал зохион байгуулахгүй, гишүүдийн хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлын талаар санал хураалт, гаргасан шийдвэр зэргийг тусгасан хурлын тэмдэглэл хөтлүүлээгүй, төсөв, санхүү, худалдан авах бараа, ажил үйлчилгээтэй холбоотой зарим асуудлыг шийдвэрлэж, эрх олгосон зөрчил нийтлэг байна. Тухайлбал:

№	ТУЗ-ын нэр	Огноо	Дугаар	Тогтоолын товч утга
1	Чандмань Илч ХХК	2018.12.04	03	2019 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө батлах
2	Чандмань Илч ХХК	2019.04.30	30	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
3	Чандмань Илч ХХК	2017.12.28	10	2018 оны үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө батлах
4	Замын-Үүд НААҮ ОНӨХХК	2018.02.02	01	2018 оны бизнес төлөвлөгөө батлах
5	Замын-Үүд НААҮ ОНӨХХК	2018.02.08	02	Зээл авах эрх олгох
6	Чандмань-Бадрал ХХК	2018.07.02	14	Автомашин худалдан авах эрх олгох

¹Компаний тухай 76.1-д Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 76.1.1.компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

²Компаний тухай хуулийн 17.1.Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална. 17.9. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

- Чандмань Илч ХХК-ийн ТУЗ-ын дарга гишүүдийнхээ хурлаар хэлэлцүүлээгүй компанийн төсөв баталж, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн ТУЗ-ийн дарга тухайн жилийн бизнес төлөвлөгөөг гишүүдийн хурлаар хэлэлцүүлээгүй баталж, арилжааны банкнаас 30.0 сая төгрөгийн зээл авах эрхийг захиралд олгосон.
- Чандмань-Бадрал ХХК-ийн ТУЗ-ийн дарга гишүүдийнхээ хурлаар хэлэлцүүлээгүй 25.0 сая төгрөгөөр суудлын автомашин худалдан авах эрхийг компанийн захиралд олгосон.

Орон нутгийн өмчит ААНБ компанийн дүрэмд заасны дагуу тухайн жилийн бизнес, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө батлуулаагүй, зөвхөн тайлант оны борлуулалтын орлого, зардлын төсвийг баталж, худалдах авах бараа, ажил үйлчилгээг төлөвлөдөггүй байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг даргын 2010 оны А/10 тоот захирамжаар батлагдсан Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ-ын дүрмийн 2.5-д *“тус газар нь ашигт ажиллагааны зорилтот түвшнийг тодорхойлсон тухайн жилийн үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг батлуулна”* гэж заасан байтал ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр тогтоолоор 2018 оны борлуулалтын орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна. Батлагдсан төлөвлөгөөнд тухайн жилд худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийг тусгаж өгөөгүй байна.
- Аймгийн ИТХ-ын 2016 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Чандмань-Илч хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 6.6.(д)-т *“Гүйцэтгэх захирал нь компанийн үйлдвэрлэл, төсөв төлөвлөгөөг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах, тайлагнах гэж заасан”*. Гэтэл ТУЗ-ийн 2017 оны 10 дугаар тогтоолоор компанийн 2018 оны төсөв нь батлагдаж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний талаар төлөвлөж батлуулаагүй байна.
- НААҮ ОНӨ ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 тогтоолоор компанийн санхүүжилт болон үйл ажиллагааны орлогын хэмжээ, шаардлагатай зардлын жагсаалт батлагдсан бөгөөд худалдан авах бараа ажил үйлчилгээ байхгүй байна.

Харин Чандмань-Бадрал ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 тогтоолоор батлагдсан компанийн 2018 оны бизнес төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын ажлыг тодорхой төлөвлөж тусгасан байна.

2. Компаниуд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

2.1 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны А/10 тоот захирамжаар батлагдсан Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ-ын дүрмийн 3.14-т *“Тухайн оны хэрэгцээт эм эмнэлгийн хэрэгслийг худалдан авах үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох дүрэм журмыг мөрдөнө”* гэж заасан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/837 дугаар захирамжийг томилогдсон Үнэлгээний хороо нь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэг,

“Эм эргэлтийн сан” ОНӨ ААТҮГ-ын хэрэгцээнд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж, тендерийн урилгыг олон нийтийн хэвлэл мэдээлэл, ЗГ-ын ХАА-ны www.tender.gov.mn цахим хуудаст байршуулан эм, эмнэлгийн хэрэгслийг 33 багцад хувааж тендерийг зарласнаар 31 багцад давхардсан тоогоор 68 ААНБ-аас тендерийн материал бэлтгэн ирүүлснийг үнэлгээний хорооноос үнэлгээ хийж, 7 багцад дахин тендер зарлаж, нийт 33 багцад 10 компанийг шалгаруулж, дүгнэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

“Эм эргэлтийн сан” ОНӨ ААТҮГ-ын хэрэгцээнд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэхээр 23 багцад 10 аж ахуйн нэгж шалгарч нийт 1.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулах эрх олгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2006 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Чандмань-Илч хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 3.7-д “Компанийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд сонгон шалгаруулалт явуулах” гэж заасан.

Чандмань Илч ОНӨ ХХК 2018 онд өөрийн хөрөнгө оруулалтаар нийт 2113.3 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Тус компани нь тайлант онд худалдан авах ажиллагааны 8 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 27 хувийг харьцуулалтын, 65 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулжээ.

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, мөнгөн дүнг хүснэгтээр харуулав. /Сая төгрөгөөр/

№	Төсөл арга хэмжээний нэр	TAX-ний тоо	Мөнгөн дүн
1	Түүхий эд худалдан авах	5	1254.20
2	Шатах тослох материал	1	235.96
3	Программ хангамж	3	35.47
4	Орон сууц	1	17.00
5	Машин, тоног төхөөрөмж	7	460.58
6	Хөдөлмөр хамгаалал	5	39.32
7	Засвар, үйлчилгээ	4	70.78
	Нийт дүн	26	2113.30

МУ-ын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тушаалд босго үнэ “харьцуулалтын аргаар худалдаж авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 50.0 сая төгрөг”, “шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10.0 сая төгрөг, ажил 10.0 сая төгрөг” гэж заасан. Гэтэл 50.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа нийлүүлэх ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулаагүй харьцуулалтын аргаар болон шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Тухайлбал:

- Цахилгааны давтамж хувиргагчийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил: Компанийн захирлын 2018 оны А/25 тоот тушаалаар томилогдсон Үнэлгээний хороо босго үнэд багтаах зорилгоор төсөвт өртгийн хэмжээг бууруулж нийт 80.0 гаруй сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулж БНХАУ-ын Fubang trading компанийг шалгаруулж гэрээ байгуулсан.

- *Автомат худгийн иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил:* Аудитын явцад худалдан авах ажиллагаа зохион байгуулсан тендерийн баримт бичиг ирүүлээгүй бөгөөд Автомат худгийн иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах нийт 119.0 сая төгрөгийн шууд гэрээг Баялаг говь ХХК-тай байгуулсан.
- Нүүрс худалдах, худалдан авах нийт 1230.0 сая төгрөгийн шууд гэрээг Шивээ-Овоо ХК, Сэнж сант ХХК, Мига эрин ХХК зэрэг ААНБ-тай байгуулсан.

Чандмань-Илч ХХК 100.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гадаадын компани оролцуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 9.3-д *“Энэ хуулийн 9.2-т³ зааснаас бусад тендер шалгаруулалтад гадаадын этгээдийг оролцуулж үл болно”* гэсэн заалтыг зөрчиж байна.

Төсөвт өртөг нь 10.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй бараа болон ажлыг харьцуулалтын арга хэрэглэх байтал шууд гэрээ байгуулсан байна. Тухайлбал:

- Чандмань-Илч ОНӨ ХХК-ийн Халуун усны засварын ажил: Сайншанд сумын 1-р багийн Халуун усны барилгын дотор засварын ажлыг гүйцэтгэх 15.6 сая төгрөгийн шууд гэрээг иргэн Ц.Ариунбаттай байгуулсан.
- Чандмань-Илч ХХК-ийн Дулааны зуухны фильтерийн сэргээлтэд ашиглах бор давс нийлүүлэх ажил: Бараа бөөнөөр худалдах, худалдан авах нийт 23.5 сая төгрөгийн шууд гэрээг Баянбогд Өргөө ХХК-тай байгуулсан

Чандмань-Илч ОНӨ ХХК-ийн зарим Үнэлгээний хороо тендерийн үнэлгээг хийхдээ ТБОНӨХБАҮХАТ хуулийн⁴ заалтыг мөрдөөгүй, шалгуур хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан байна. Тухайлбал:

- “Салаа төмөр замын арчилгаа, үйлчилгээ хийх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Дорнын харгуй ХХК Тендерийн баримт бичигт тусгасан шалгуур хангаагүй, үе шатны ажлын хуваарь, тоног төхөөрөмжийн судалгаа, ажлын туршлага мэдээлэл ирүүлээгүй, өндөр үнийн санал ирүүлсэн.
- “Тусгай зориулалтын дугуй ачигч” нийлүүлэхээр шалгарсан Ундрах шанд ХХК Тендерийн баримт бичигт тусгасан шалгуур хангаагүй.

Чандмань Илч ОНӨ ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөл болон захирлын хооронд байгуулсан 2018 оны 01 тоот гэрээний 4.3-д *“Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан 2018 оны санхүүгийн төлөвлөгөөний хүрээнд үйлдвэрлэлийн туршилт, технологийн шинэчлэлтэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг худалдан авах үйл ажиллагааг тухай бүрд ТУЗ-ийн гишүүдэд танилцуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах”* гэж заасан. Харилцагч талууд хууль,

³ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 9.2-д Захиалагч нь 10,000,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 100,000,001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно.

⁴ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12.1.Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана. 16.1.Тендерт оролцогчийн техникийн чадавх, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараах үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно: 16.1.1.тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар; 16.1.2.сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт; 16.1.4.тендерт оролцогчийн багаж, техник хэрэгслийн тодорхойлолт, үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийн жагсаалт;

дүрэм, журмыг мөрдөж ажиллаагүйгээс гэрээний заалт хангалтгүй хэрэгжиж, худалдан авалттай холбоотой зөрчлүүд давтагдан гарсан байна.

Замын-Үүд сумын Засаг даргын 2017 оны А/58 тоот захирамжаар батлагдсан Чандмань-Бадрал ХХК-ний дүрмийн 6.4-д “Гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэ дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна” гэж заасан байна.

Чандмань-Бадрал ОНӨ ХХК 2018 онд өөрийн хөрөнгө оруулалтаар нийт 1036.7 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээ хэрэгжүүлж, худалдан авалт хийхдээ тендер огт зарлаагүй, үнийн харьцуулалт хийгээгүй, шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хууль, МУ-ын Засгийн 2013 оны 68 дугаар тушаалын заалтыг тус тус зөрчиж байна.

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, мөнгөн дүнг хүснэгтээр харуулав.

			/сая.төг/
№	Төсөл арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
1	Түүхий эд	11	681.2
2	Шатах тослох материал	1	93.6
3	Машин, тоног төхөөрөмж	8	139.9
4	Хөдөлмөр хамгаалал	3	29.8
5	Засвар, үйлчилгээ	15	92.2
	Дүн	38	1,036.8

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6.1-д Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална гэж заасан. Гэтэл Чандмань-Бадрал ОНӨ ХХК-ийн зарим худалдан авалт үр ашиггүй, зардал их шаардсан, дахин шинэчлэхээр байгаа нь худалдан авах ажиллагааны зарчимд нийцэхгүй байна. Тухайлбал:

- Чандмань-Бадрал ОНӨ ХХК-ийн захирлын 2018 оны А/74 тоот тушаалаар БНХАУ-ын Хунда компаниас DZL4.2 мвт, DZL2.8 мвт маркийн 2 ш зуухыг 130.0 сая төгрөгөөр худалдан авахаар шийдвэрлэж, шууд гэрээ байгуулсан байна.
- Ашиглагдаж байсан хуучин зуух худалдан авсан бөгөөд зуухны ул ширэм нь сорогдож хуучирсан, хоорондын зай завсар ихтэй тул нүүрс дутуу шатаж эд анги эвдрэх, утаа тортог их гардаг зэргээр технологийн шаардлага хангахгүй байсан тул 2019 онд 38.0 сая төгрөгөөр ул ширэм солихоор шийдвэрлэсэн байна.
- Эдгээр зуухыг ашигласнаар цахилгааны зардал 50 хувь, нүүрсний зардал 25 хувиар нэмэгдсэн.

Иймд Чандмань-Бадрал ОНӨ ХХК-ийн дээрх худалдан авалттай холбоотой 170.0 гаруй сая төгрөгийн асуудлыг нягтлан шалгуулахаар хууль хяналтын байгууллагад хандахаар шийдвэрлэв.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК нь тайланд онд 171.9 сая төгрөгийн 34 бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна. Тус компани нь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ихэнх ажлыг өөрийн нөөц боломжоо дайчлан гүйцэтгэж байгаа нь үр

ашигтай ч худалдан авах ажиллагааны хууль⁵, барилгын тухай хууль⁶, холбогдох журмын заалтыг⁷ мөрдөж ажиллаагүй. *Тайлант онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээг хүснэгтээр харуулав. /Сая төгрөг/*

№	ТАХ-ний нэр	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
1	Барилга байгууламж барих	4	62.77
2	Автомашин худалдан авах	1	29.30
3	Шинээр хөрөнгө бэлтгэх	10	59.33
4	Барилгын засвар, үйлчилгээ	2	3.05
5	Автомашин засвар, үйлчилгээ	7	4.73
6	Нохой устгалын ажил	4	8.64
7	Шатах, тослох материал	1	0.70
8	Нүүрс	1	0.93
9	Бусад ажил үйлчилгээ	4	2.49
	Дүн	34	171.91

Төсөвт өртөг нь 10.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй бараа болон ажлыг харьцуулалтын арга хэрэглэж худалдан авах байтал шууд гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ийн Хурлын заалны /конторын түр барилга/ барилга, сахиулын барилга шинээр барих нийт 27.3 сая төгрөгийн /материалын зардал/ ажил: Барилгын ажлыг батлагдсан төсөвт өртөг, зураг төсөлгүй гүйцэтгэсэн бөгөөд ашиглалтад оруулж, бүртгэлд тусгаагүй байна.
- Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн Автомашин худалдан авах ажил: Автомашин худалдан авах 29.3 сая төгрөгийн шууд гэрээг иргэн М.Мөнхдалайтай байгуулсан
- Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн Ажилчдын халуун усны барилга шинээр барих 35.0 сая төгрөгийн ажил: Барилгын ажлыг батлагдсан зураг төсөлгүй гүйцэтгэсэн.

Шинээр баригдсан хурлын заалны барилгыг журмын дагуу ашиглалтад оруулж, бүртгэлд тусгуулах албан шаардлага бичихээр шийдвэрлэв.

Говийн догшин ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 215 жилийн ойн баяр наадмын хүрээнд Нийтлэг үйлчилгээний газрын арилжааны банкин дахь дансанд ААНБ-аас нийт 1.5 тэрбум төгрөгийн хандив цугларч, баярын арга хэмжээний зардал болон хөрөнгө оруулалт арга хэмжээнд зарцуулжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг тусгах учиртай. Хандивын хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах төсөл арга хэмжээ хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй бөгөөд иргэн ААНБ-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Тухайлбал:

⁵ ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1.1-д харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар; 8.1.2-д шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

⁶ Барилгын тухай хуулийн 37.6-д Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно. 40.2-д Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

⁷ МУ-ын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тушаалд босго үнэ “харьцуулалтын аргаар худалдаж авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 50.0 сая төгрөг”, “шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10.0 сая төгрөг, ажил 10.0 сая төгрөг” гэж заасан.

- МССТ-ийн барилгын засварын 79.6 сая төгрөгийн ажил
- Хилэнцэт хөшөөний суурь, талбайн тохижилт хийх 46.6 сая төгрөгийн ажил
- Саран хөхөө театрын гадна фасад, зам талбайн засварын 112.0 сая төгрөгийн ажил

Энэ нь төсвийн тухай хуулийн⁸ 29.3, 29.3.3, 29.3.4 заалтыг тус тус зөрчсөн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.3-д Үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах гэсэн заалтыг Чандмань-Илч ХХК, ЭЭС ОНӨ АТҮГ-ын удирдлагууд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.1-д Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна гэсэн заалтыг зарим орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллага мөрдөөгүй байна.

Аудитад хамрагдсан бүх орон нутгийн өмчит ХХК, үйлдвэр газрууд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.1-д Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна. Мөн Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад цахим хуудаст ХАА-ны төлөвлөгөө, тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг журмын дагуу зарлан мэдээлдэггүй байна.

2.2 Зарим худалдан авалтын үр дүнд зардал буурч, хэмнэлт үүссэн байна.

Төсөл, арга хэмжээний зарим зардлыг хэмнэж, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн: Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх “Жишиг хашаа барих” 50.0 сая төгрөгийн ажлын тендерт туслан гүйцэтгэгчээр оролцож, ажлыг бүрэн гүйцэтгэн, цалин хөлс, тээврийн зардлаас 10.0 гаруй сая төгрөгийн хэмнэлт үүсэж, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна.

Техник, технологийн шинэчлэлт өөрчлөлт хийж цахилгааны зардлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт үүссэн: Эрчим сүлжээ ХХК 2018 онд Чандмань Илч ХХК-д эрчим хүчний аудит хийж, эрчим хүчний хэрэглээ өндөртэй тоног төхөөрөмжүүд дээр эрчим хүч хэмнэх аргачлал, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, хэмнэлт, үр ашгийн талаар зөвлөмж, дүгнэлт өгсөн байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу тус компани “Эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөө” боловсруулан, цахилгаан хөдөлгүүр бүрд үе шаттайгаар давтамж хувиргуур шинээр бэлтгэн суурилуулж, дулааны станцын сүлжээний усны насос шинэчлэхээр төлөвлөж, техник технологийн өөрчлөлтийг гүйцэтгэснээр цахилгаан эрчим хүчний хэмнэлт үүсэж, суурилагдсан тоног төхөөрөмж бүрд цахилгааны хэрэглээ 10-20 хувиар буурсан байна. Тус компанийн цахилгааны хэрэглээг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

⁸ Төсвийн тухай хуудийн 29.3-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.3-д нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах; 29.3.4-д санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

Цахилгааны хэрэглээ	2016 он	2017 он	2018 он
Квт.ц сая	4.54	4.33	4.15

2.3 Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх, тайлагнах ажил хангалтгүй байна.

“Эм эргэлтийн сан” ОНӨ ААТҮГ-ын хэрэгцээнд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэхээр 23 багцад 10 аж ахуйн нэгж шалгарч нийт 1.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна. Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх аж ахуй нэгж байгууллагын нийт гэрээний хэрэгжилт 55 хувьтай байна. ААНБ-ын гэрээний хэрэгжилтийг хүснэгт харуулав. /Сая.төгрөгөөр/

Нийлүүлэгч ААНБ	Батлагдсан төсөв	Шалгарсан дүн	Гэрээний үнэ	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Гүйцэтгэл хувиар
Эм импекс ХХК	35.6	35.6	35.6	19.1	16.5	54%
Монос фарм трейд	105.9	112.6	112.6	60.4	52.2	54%
Монфа трейд	452.7	418.2	418.2	212.0	206.1	51%
Тавин Ус ХХК	8.7	8.7	8.7	4.1	4.6	47%
Мөнхийн түн ХХК	94.5	85.3	85.3	49.1	36.2	58%
Нугантрейд ХХК	6.9	6.2	6.2	3.2	3.1	51%
Чоногол ХХК	51.9	49.3	49.3	30.5	18.7	62%
Монголфарм ХХК	66.9	54.4	54.4	45.1	9.3	83%
Айвико интернейшнл	64.4	55.3	55.3	55.3	-	100%
Азифарм ХХК	418.1	317.5	317.5	150.3	167.2	47%
Дүн	1,305.4	1,143.1	1,143.1	629.2	514.0	55%

Эм ханган нийлүүлэгч нарын нийт гэрээний хэрэгжилт 55 хувьтай байна. Тухайн жилийнхээ хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоогүй, зарим багцын тендер дахин зарлагдаж хугацаа алдсанаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл хугацаандаа нийлүүлэгдээгүй, гүйцэтгэгч захиалгын тоо хэмжээнээс дутуу нийлүүлсэн, хөрөнгө санхүүгийн хүндрэл зэрэг нь гэрээний хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК тайланд онд 9 төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах 171.9 сая төгрөгийн гэрээг 34 иргэн, ААНБ-тай байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна.

Чандмань Илч ОНӨ ХХК 2018 онд нийт 26 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр иргэн ААНБ-тай ажил гүйцэтгэх, худалдах худалдан авах 2113.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Ажил гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, үнийн дүн, хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй байх зөрчил нийтлэг байна. Тухайлбал:

- Хөдөлмөр хамгааллын зуны хувцас, гутал нийлүүлэх нийт 16.3 сая төгрөгийн гэрээг Болор ирээдүй ХХК-тай байгуулж, 35.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Өвлийн тусгай хувцас, өвлийн гутал нийлүүлэх гэрээнд нийлүүлэх барааны тоо хэмжээ, үнэ тусгагдаагүй байхад 18.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Автомат худгийн иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэх /14 худагт/ нийт 119.0 сая төгрөгийн гэрээг Баялаг говь ХХК-тай байгуулж, 127.6 сая төгрөгийн

буюу гэрээний үнийн дүнгээс 8.6 сая төгрөгийг санхүүжилт илүү олгосон /Айраг салбараас баримт авах/.

Чандмань-Бадрал ХХК тайланд онд 38 бараа, ажил үйлчилгээнд 1036.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Ажил гүйцэтгэх гэрээнд ажлын тоо хэмжээ, огноо, үнийн дүн, хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй зөрчил нийтлэг байна.Үүнд:

- Хөдөлмөр хамгааллын хувцас, гутал нийлүүлэх гэрээг Болор-Ирээдүй ХХК-тай байгуулсан боловч барааны тоо хэмжээ, үнийн дүн тусгагдаагүй байхад 17.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Бараа, ажил үйлчилгээ худалдах авах гэрээний хэрэгжилтийг дүгнэх, нийлүүлсэн бараа болон гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч акт үйлдэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн

Бүлэг 2

Худалдан авах ажиллагаанд шат шатны хяналт дутагдаж байна.


2.1.Компанийн худалдан авах ажиллагаанд тавих хяналт дутагдаж байна.

2.1.1.Бэлтгэсэн хөрөнгө, бараа материалын чанар, үр ашигт хяналт дутагдаж байна.

Байгууллагуудын бэлтгэсэн хөрөнгүүд нь ашиглалтын шаардлагыг хангадаг ч зарим тохиолдолд хямд үнэтэй авч ирсэн сэлбэг, төхөөрөмж шаардлага хангадаггүй, ийм үед худалдаж авсан газартаа эргүүлж өгч сольж авдаг байна. Усны насос эдэлгээний хугацаа нормдоо хүрэхгүй байх, захиалж авч ирсэн хангамжийн материал, хөдөлмөр хамгааллын хувцас ашиглалтын шаардлага хангаагүй гэх мэт асуудал бага хэмжээгээр гардаг байна.

Авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник ашиглалтын дэвтэр дээрх үзүүлэлтийг аль ч байгууллага бүрэн хөтлөөгүй байдал түгээмэл байна. Тухайлбал: техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, техникийн үйлчилгээ, урсгал засвар, их засварын бүртгэлүүд хөтлөгдөөгүй байна.

Энэ нь тухайн техник хэрэгслийн тогтоосон эдэлгээний норм, норматив, ажиллах хүчин чадал, гүйцэтгэл, зарцуулсан сэлбэг материалын тоо, дүн болон техник хэрэгсэл, эд ангиудын засвар үйлчилгээнд хэрэглэсэн материалын чанар, таарч тохирсон эсэх, ямар хугацаанд дахин үйлчилгээ хийгдээд байгаад тавих хяналтыг алдагдуулж байна.



Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК 2018 оны байдлаар 769.0 сая төгрөгийн 25 тээврийн техник хэрэгсэлтэй байна. Үүний 60 гаруй хувь нь 2014 оноос өмнө ашиглалтад орсон бөгөөд техникийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн зардал нэлээдгүй гарчээ. Тухайлбал:2018 онд эргэлтийн нийт хөрөнгийн 22.4 хувь буюу 120 нэр төрлийн 34.2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч зарцуулсан байна.

Тээврийн хэрэгслийн техникийн байдлын талаар МХГ-аас 2018 онд 3 удаа дүгнэлт гаргаж, зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн байна. Шалгалтаар зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн насжилт нь стандартаар тогтоосон хэмжээнээс хэтэрсэн, хог зөөврийн тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн хэвийн ажиллагаа алдагдсан, гүйлтийн нөөц багассан, хөдөлмөр зарцуулалт, засвар үйлчилгээ их шаардагдах болсон, тээврийн хэрэгслийн агергат зангилаа, эд ангид үйлчилгээ хийх зориулалтын ажлын байргүй, мэргэжлийн засварчин, инженер техникийн ажилчдаар хангагдаагүй, өөрөө буулгагч авто машины төхөөрөмж бүрэн бус, өргөх механизмын тогтоох чадвар алдагдсан зэрэг зөрчил нь холбогдох стандартуудыг зөрчсөн гэсэн дүгнэлт өгчээ.

Зарим хуучны техник хэрэгслийн сэлбэг олддоггүй байна. Машин, техник эвдрэхэд захиалгын хуудас бичихгүйгээр амаар болон цаасан дээр тэмдэглэл хөтлөх, биетээр нь авч явж ижлийг нь авч явах зэргээр тухайн өдөрт нь Эрээн хотоос бэлтгэдэг байна.

Аудитад хамрагдаж байгаа ОНӨ ХХК-иуд байгууллагын онцлогт тохируулан өдөр тутам зарцуулах бэлэн мөнгөний зарцуулалт болон хяналт хэрхэн тавих талаар журам боловсруулж мөрддөөгүйгээс БНХАУ-ын Эрээн хотоос бэлэн мөнгөөр их хэмжээний материал бэлтгэдэг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг зөрчиж байна. Тухайлбал:

Чандмань бадрал ОНӨ ХХК-ын захирлын 2018 оны 9 сарын 28-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар 1-р зуухыг 2.4 МВт, 2-р зуухыг 3.2 МВт-ын хүчин чадалтай уурын зуух худалдан авахад зориулж 130.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж БНХАУ-ын нийлүүлэгч компанийн дансанд шилжүүлэх шийдвэр гаргасан байна.

Материалын нягтлан бодогч 2018.09.29-ний өдөр Дараа тайлангаар 336.0 мянган юань /125.9 сая төгрөг/ авч БНХАУ-ын худалдан авагч компанийн дансанд 124.0 мянган юань тушаасан байна. Үлдэх 206.0 мянган юанийг 29824 долларт хөрвүүлэн бэлнээр авч зүүх хүлээн авах засварын инженерийн хамт БНХАУ-ын

Ганжоу хот руу явахад нийлүүлэгч үнэ нэмснээс шалтгаалж касс 2018.10.08-ний өдөр 205785,6 юань буюу 77,1 сая төгрөгийг тушаасан байна. Тус худалдан авалттай холбоотой гадаад албан томилолтын зардалд 6000 юань, ханшийн зөрүү 215 юань /нийт 2,3 сая төгрөг/ зарцуулсан байв.

2018.10.06-ний өдөр дараа тооцоот материалын үлдэгдэл тооцоо гэж 206.0 мянган юань буюу 77.2 сая төгрөгийг, 2018.10.11-ний өдөр зуухны тээврийн зардалд 21,5 мянган юань буюу 8180.8 мянган төгрөг төлснөөр нийт зардал 351,5 мянган юань буюу нийт 132.3 сая төгрөгийг кассаас гарган зарцуулсан байна.

Гадаад улсаас их хэмжээний дүнтэй худалдан авалтыг хийхдээ томилсон ажилтны амь нас, байгууллагын хөрөнгө мөнгө үрэгдэх зэрэг учирч болох эрсдэлийг тооцоогүй, төлөвлөөгүй зардлуудыг гаргасан байгаа нь худалдан авах ажиллагааг хариуцлагагүй, үр ашиггүй зохион байгуулсныг харуулж байна.

Бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд дараах үнээр бүртгэсэн ба тээврийн зардлын 8.2 сая төгрөгийг хөрөнгийн үнэд шингээгээгүй байна. Энэ зөрчилд зөвлөмж өгөх.

DZL 4.2 зуух 67,446.0 мянган төгрөг
DZL 2.8 зуух 48,711.0 мянган төгрөг,
Бойлуур 7,494.0 мянган төгрөг

Тухайн зуухнуудыг худалдан авснаар компанийн цахилгааны зардал, нүүрсний зардал өссөн ба нэмэлт зардлууд гарсаар байна. Үүнд: 2018 оны 1 дүгээр сард 81,346.9 мянган төгрөгийн 2,249.9 тонн нүүрс зарцуулсан бол 2019 оны 1 дүгээр сард 137,314.6 мянган төгрөгийн 3,549.6 тонн нүүрс зарцуулсан байна. Өмнөх оны мөн үеэс нүүрсний зардал 55.9 сая төгрөгөөр, нүүрсний тоо хэмжээ 1,299.7 тн-оор тус тус нэмэгдсэн байна.

Цахилгааны зардал 1, 2 дугаар зуух дээр 2017 онд 78,530 квт, 14,156.3 мянган төгрөг байсан бол 2018 онд 152,342 квт, 27,479.9 төгрөг болж 73,812 квт буюу 13,323.6 сая төгрөгөөр өсжээ.

2.1.2. Худалдан авсан ажил үйлчилгээ, хөрөнгө, бараа материалын төлбөр тооцоо, бүртгэл хөтлөлтөд тухай бүр хяналт тавьж хөрөнгө шамшигдахаас сэргийлэх шаардлагатай байна.

Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ-ын харилцах дансны зарлагын гүйлгээгээр эм ханган нийлүүлэх 17 байгууллагад нийт 1002.0 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 23.4 сая төгрөгийн өртэй гарсан байна. Дансны авлага 69.6 мянган төгрөг байгаа нь сумдын ЭМТ-үүд болон төсвийн байгууллагаас авах авлага байна.

Тус байгууллагын эд хариуцагч /ажлаас чөлөөлөгдсөн/ 2018 оны 1-7 дугаар саруудад харилцах данснаас дараа тайлангаар, нийт /4 удаагийн гүйлгээ/ 15.0 сая төгрөгийг бэлнээр авсан байх ба мөнгөний зарцуулалтын тайлан гаргаагүй, харилцах дансанд 12-31 хоногийн дараа мөнгийг буцааж тушаасан байв.

Дараа тайлан гаргахаар авсан		Буцааж тушаасан		Гар дээр байсан хоног
огноо	Мөнгөн дүн /сая төгрөг/	огноо	Мөнгөн дүн /сая төгрөг/	
2018.01.04	4.0	2018.01.29	4.0	25
2018.02.07	4.0	2018.02.19	4.0	12
2018.03.02	5.0	2018.03.27	5.0	25
2018.07.20	2.0	2018.08.01	2.0	31
Дүн	15.0		15.0	

Байгууллагын ХААН банкин дахь 5360367927 тоот харилцах данснаас 2018.08.12-ны өдөр хүлээн авагч байгууллагын нэрийг “Эм эргэлтийн сан”, гүйлгээний утгыг эмийн үнэ гэж бичсэн 2 гүйлгээ гарсныг тодруулахад 7.9 сая төгрөгийн гүйлгээ нь Дорноговь эм импекс ХХК-д харилцагч байгууллагын нэрийг буруу бичиж шилжүүлсэн, тус компанийн нягтлан бодогч нь /ажлаас чөлөөлөгдсөн/ 5.6 сая төгрөгийг хувьдаа авч завшсаныг компаниас барагдуулах арга хэмжээ авснаар 2019 онд барагдуулсан байна.

огноо	Хүлээн авагч		Гүйлгээний дүн	Тайлбар
	байгууллагын нэр	дансны дугаар		
2018.08.12	Эм эргэлтийн сан	5077120357	5,600,000	Хувь хүний данс
2018.08.12	Эм эргэлтийн сан	5360001360	7,926,350	Дорноговь Эм импекс ХХК-ны данс байв.

Дээрх 20.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөх

Тайлант хугацааны сүүлийн хагас жилд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх компаниудын гэрээний биелэлтийг тооцож нийлүүлэх тоо хэмжээнээс илүү хүлээн авсан эмийг Монфа ХХК, Тавин ус ХХК, Ази фарм ХХК-д буцаан хүргүүлсэн, захиалсан саруудад нийлүүлэгдээгүй эмийг хүлээн авахгүй боломжгүйг холбогдох компаниудад мэдэгдэж ажилласнаар төлбөр тооцоог үнэн зөв хийх, мөнгөн хөрөнгийн эргэлт удаашрах эрсдэлээс сэргийлж ажилласан байна.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК нийт орлогын 70 орчим хувийг орон нутгийн төсвийн санхүүжилт эзэлдэг байна. Төсвийн санхүүжилт, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос НӨАТ, нийтийн эзэмшлийн хөрөнгө, хашаа, зам талбай, худаг, түүний барилгууд, халуун ус, машины граж зэрэг хөрөнгүүдийн үл хөдлөх хөрөнгийн татварыг төлдөг байна. 2018 оны эцсийн санхүүгийн тайлангаар НӨАТ-ын өр 31.6 сая төгрөг, бусад татварын өр 5.7 сая төгрөг байна.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар шинээр баригдах 284 айлын Мандах наран хорооллын инженерийн шугам сүлжээ, авто зам хийх ажлын нэгдүгээр багцын инженерийн шугам сүлжээ хийх ажлын тендерт Чандмань бадрал ОНӨ ХХК шалгарч захиалагчтай ажил гүйцэтгэх гэрээг 2018.07.20-ны өдөр байгуулж, тус ажлыг 2018.07.20-10.20-ны хугацаанд гүйцэтгэх, 478.0 сая төгрөгийн санхүүжилт авахаас тайлант онд 100.0 сая төгрөгийг, үлдэх хэсгийг дараа онд санхүүжүүлэхээр тусгажээ. Энэхүү 478.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөх

Энэхүү багцад Мандах наран хорооллын гадна ус, дулаан хангамжийн шугамын угсралтын ажлын гэрээний дүн 236.5 сая төгрөг, ариутгах татуургын шугамын угсралтын ажил 119.9 сая төгрөг, бохирын өргөтгөлийн насосны барилгын угсралтын ажил 123.3 сая төгрөгийн 3 төрлийн ажил орсон байна.

Чандмань бадрал ОНӨ ХХК эдгээр ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж ажлын гүйцэтгэлийг 2018 оны 10 сарын 30-нд гаргаж өгсөн байтал өнөөг хүртэл техникийн комисс, улсын комисс хүлээж аваагүй, санхүүжилтээ аваагүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар сумын ЗДТГ-аас 360.9 сая төгрөгийн авлагатай гарчээ. Энэ байдал нь тус компанийн мөнгөн хөрөнгийн эргэлтийг удаашруулж ашигт ажиллагааг бууруулж байна.

Чандмань бадрал ХХК Бохирын өргөтгөлийн насосны барилгын угсралтын ажлыг Цагаан манлай ХХК-аар туслан гүйцэтгүүлэхээр 2018 оны 7 сарын 24-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Гэрээний нийт үнэ болох 110.0 төгрөгийн төлбөр тооцоог хийхдээ ажил эхлэхэд 60 хувь болох 66.0 сая төгрөгийг төлж, үлдэх 44.0 сая төгрөгийг дараа онд багтаан төлнө, энэхүү ажлыг гүйцэтгэхэд ашиглагдах машин механизмын зардал 5.9 сая төгрөгийг үлдэгдэл санхүүжилтээс хасаж тооцохоор гэрээнд тусгажээ.

Цагаан манлай ХХК Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 105 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн ажлуудын актуудыг үйлдсэн байна. Улаан шугам шалгаж тэг тэнхлэг тавих ажил 8 сарын 13-нд эхэлж гадна зам талбайн тохижилт хийсэн ажлын актыг 2018 оны 11 сарын 21-нд үйлдсэн байхад Чандмань бадрал ХХК гэрээ байгуулсны дараагийн өдөр /2018 оны 07 сарын 25/ 66.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид шилжүүлсэн байна.

Тус ажлыг гүйцэтгэх гэрээний төлбөр тооцоо хийх хугацааг харахад ажил эхлээгүй, ажлын гүйцэтгэл гараагүй байх хугацаанд санхүүжилтийг олгохоор заасан байгаа нь гүйцэтгэгч компанид илтэд давуу байдал үүсгэсэн ба МУ-ын Эрүүгийн хуулийн 22.12.1-т *“Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хувьдаа, бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар Сүлд багийн 11 дүгээр хэсгийн ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг Чандмань бадрал ОНӨ ХХК-аар гүйцэтгүүлэхээр 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулсан ба гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг 2018 оны 12 сарын 21-ний өдөр эхэлж, 2018 оны 7 сарын 1-ний өдөр гүйцэтгэнэ гэж буруу бичсэн байв.

Төсвийн тухай хуулийг зөрчиж зураг, төсөв нь бэлэн болоогүй хөрөнгөнд сумын ИТХ төсөв баталсан, ажлын гүйцэтгэл гараагүй байхад гэрээ байгуулснаас хойш 3 өдрийн дараа төрийн сангаас 19.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон, тухайн ажил өнөөг хүртэл гэрээний дагуу хийгдээгүй байна. Иймд Чандмань бадрал ХХК-аар хийгдээгүй ажлын санхүүжилтийн мөнгийг Замын-үүд сумын төсөвт төлүүлэхээр 19.8 сая төгрөгийн нэг төлбөрийн акт бичив.

Чандмань-Илч ОНӨ ХХК үндсэн үйл ажиллагааны болон тендерээр гүйцэтгэх ажилд шаардлагатай бараа материалыг ихэвчлэн БНХАУ-ын Эрээн хотоос бэлтгэсэн байв.

Бараа материал, сэлбэг, төхөөрөмж авахаар 2.0 саяас дээш хэмжээний мөнгө хүлээн авч тооцоо хийсэн албан тушаалтны судалгаа:

Албан тушаал	Банкны нэр	мөнгө авсан өдөр, удаа	Мөнгөн дүн	Мөнгөний зарцуулалтын дүн
ТҮА-ны дарга	ХААН	2	17,540.0	17,868.1
ТҮА-ны дарга	ХААН,Хас	3	53,168.5	61,174.2
ТҮА-ны дарга	ХААН,Хас, касс	8	193,523.0	284,446.0
Жолооч	ХААН,Хас	2	2,200.0	1,038.0
ТҮА-ны дарга	ХААН,Хас, ХХБ касс	7	333,886.5	342,463.1
ТҮА-ны дарга	ХХБ	1	28,880.0	-
ТҮА-ны дарга	хас	1	74,360.0	-
эд хариуцагч	ХААН, ХАС	4	50,330.0	50,127.1
эд хариуцагч	ХААН	3	12,800.0	12,789.5
ТҮА-ны дарга	ХАС	1	37,630.0	-
ТҮА-ны дарга	ХААН	3	30,699.8	30,699.8
ТҮА-ны дарга	ХАС	1	19,325.0	-
ТҮА-ны дарга	ХАС	1	38,730.0	-
Ерөнхий нягтлан бодогч	ХААН	1	3,500.0	4,194.2
Дүн		38	896,572.8	804,800.0

Бараа материалыг Техник үйлчилгээний албаны дарга /хангамжийн албаны ажлыг хавсран гүйцэтгэгч/ явж авдаг бөгөөд бэлнээр мөнгө урьдчилан авч явах, тус ажилтны хувийн харилцах дансанд дараа тооцоогоор мөнгө шилжүүлэх, хятад дэлгүүрийн эзний дансаар мөнгө шилжүүлэн төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Тус байгууллагын Эрээнээс авсан бараа материалын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл нь ойлгомжгүй, эмх замбараагүй байв.

“Ажилтан албан хаагчдад дараа тайлангаар урьдчилгаа” гэсэн нэртэй дансанд Техник үйлчилгээний албаны даргын материал, хөрөнгө бэлтгэсэн ажил гүйлгээний дүн 1025.6 сая төгрөг байна. Энэ гүйлгээний дүнд зөвхөн гадаад худалдан авалттай холбоотой бус дотоод худалдан авалт, тохируулах бичилт, нэр залруулах бичилтүүд орсон тухай нягтлан бодогч тайлбарлав.

БНХАУ-ын нийлүүлэгч Zhang sun lin дэлгүүрийн 2018 оны нийт худалдан авалт, өглөг, авлагын тооцоог үзэхэд:

1. Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа нэртэй дансанд 1.8 сая төгрөгийн бараа материал авч 1.4 сая төгрөгийг өр төлсөн, 0.4 сая төгрөгийг тохируулах бичилт гэж хаасан
2. Ажилтан албан хаагчдын дараа тайлангийн урьдчилгаа дансанд Адъяасүрэнгийн дараа тооцоо руу хаасан 39.8 сая төгрөг, өглөг үүсгэв гэж 8.0 сая төгрөг, үлээх салхилуур болон бусад төхөөрөмж авсан гэж 17.9 сая төгрөг нийт 65.7 сая төгрөгийн кредит гүйлгээг бүртгэсэн бол материалын үнэ 39.9 сая төгрөг, өмнөх өр 7.9 сая төгрөг, өглөг үүсгэв гэж 17.9 сая төгрөг нийт 65.7 сая төгрөгийн дебет гүйлгээг бүртгэж хаасан байна.
3. Дотоодын байгууллагуудад өгөх өглөг нэртэй дансны эхний үлдэгдэл 1.3 сая төгрөг бөгөөд өглөг үүсгэв 21.2 сая төгрөг, тохируулах бичилт 0.4 сая төгрөг нийт 21.6 сая төгрөгийн кредит гүйлгээг бүртгэсэн, 2017 оны өр төлөв гэж 0.5 сая төгрөг, ханшийн зөрүү 0.8 сая төгрөгийн дебет гүйлгээг бүртгэж 21.6 сая төгрөгийн өртэй гэсэн бүртгэл байна.

Нийлүүлэгч байгууллагын тооцоог олон дансанд хувааж бүртгэсэн нь тухайн газраас нийт хэдэн төгрөгийн бараа материал авч төлбөр тооцоог хийснийг нэг бүртгэлээр харах боломжгүй болгож байна. Мөн ахлах нягтлан бодогчоос тодруулж асуухад журналын зарим зүйлийн учрыг олохгүй байна гэсэн тайлбар өгсөн.

Аудитын явцад бараа материалын нягтлан бодогчтой хамтран дараа тайлангуудаас Zhang sun lin дэлгүүрийн тооцоог шүүж үзэхэд нийт 902.8 мянган юань буюу 336.6 сая төгрөгийн бараа материал авч 858.1 мянган юань буюу 319.8 сая төгрөг төлсөн бөгөөд 46.1 мянган юань, 17.3 сая төгрөгийн өглөгийн тооцоо гарсан. Улирал, жилийн эцэст тус газартай тооцоо нийлж өглөг, авлагаа баталгаажуулаагүй байна.

Саналд ирүүлсэн тайлбарын дагуу тооцоо нийлсэн актыг нягталж үзэхэд “тооцооны үлдэгдлийн баталгаа” гэсэн Zhang sun lin-тэй хийсэн тооцооны 3 баримт байсан бөгөөд эдгээрийн нэг нь зөвхөн гарын үсэг зурсан тоо, дүн бичигдээгүй хүчин төгөлдөр бус баримт байв. 2018 оны 7 сарын 20-7 сарын 31-ний хооронд өгч авалцсан зүйлсийн үлдэгдэл өр 266000 юань, 2018 оны 12 сарын 03-наас 12 сарын 31-ний өдрийн хооронд өгч авалцсан зүйлсийн өр 46749 юань гэсэн баримт байсан бөгөөд хэдэн төгрөгийн бараа материал хүлээн авсан тоо дүн байхгүй байна.

Дээрх байдлаас харахад бүртгэл тооцоо ойлгомжгүй, өр төлбөрийн үлдэгдэл зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг дэх дараах заалтууд зөрчигдсөн байна.

20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;

20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

ХАА-ны хууль зөрчиж хөрөнгө бэлтгэсэн, бүртгэл тооцоо нь ойлгомжгүй, тодорхой бус дараа тооцоогоор бэлтгэсэн 1025.6 сая төгрөгийн гүйлгээг хуулийн байгууллагад шалгуулахаар шийдвэрлэв.

Чандмань-Илч, Чандмань бадрал ОНӨ ХХК-иуд захиалгын хуудас бичиж хөрөнгө, материал бэлтгэдэг байна. Захиалгыг холбогдох нэгж хэсгүүдээр гаргуулан авч явдаг хэдий ч үнийн судалгааг үндэслээгүй, ямар үнээр авах тооцоо хийж нийт хэдэн төгрөгийн зардал гарахыг тооцоогүй, тухайн нэгж хэсгийн захиалгыг нэгтгэж гаргаагүй байна. Захиалгын хуудас дээр батлах, хянах үүрэг бүхий албан тушаалтнууд гарын үсэг зураагүй, дутуу, материалын нэр бичигдсэн байхад тоо хэмжээ тавиагүй, захиалгын нэр төрөл, марк, тоо хэмжээний дагуу ирснийг харьцуулсан баримт байхгүй байна. Тухайлбал:

1.Чандмань бадрал ХХК 2018 онд Эрээн хот дахь Хун шин, Баатар, Мөнгөнөө, Солонго гэсэн нэр бүхий дэлгүүрийн сангийн материалын үнэд судалгаа хийж үнийн харьцуулалт хийсэн байв. 2018 оны 7 сарын 1-нд 11 нэр төрлийн материал авах захиалгаар 5595.0 мянган төгрөг урьдчилан бэлнээр авч яваад тухайн өдрөө 3105.7 мянган төгрөгийн 13 нэр төрлийн бараа материалыг авч ирсэн ба 2489.3 мянган төгрөгийг касст тушаасан байв.

-Үнийн судалгааг үндэслэж захиалгат материалд шаардагдах мөнгөн дүнг урьдчилан тооцож төсөв гаргаагүйгээс кассаас 2.0 сая гаруй төгрөг илүү олгож явуулсан

-Захиалсан материал нь хэрэгцээтэй материал мөн эсэхэд хяналт тавиагүй

-Нэгжүүдийн захиалгыг нэгтгээгүй
 -Ирсэн бараа материалыг захиалгын дагуу бүрэн, бүтэн ирсэн эсэхэд тавьсан хяналт, бүртгэл байхгүй байна.

2.Чандмань-Илч ХХК-ны мөнгөн урьдчилгааны тайлан гаргагчдын дийлэнх нь мөнгө авсан тухай бүрд мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй, хэд хэдэн удаагийн авсан мөнгийг нийлүүлж нэг тайлан хийжээ. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх зааварт “Урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл ба олгосон урьдчилгаа, холбогдох анхан шатны баримттай харьцуулан нягтлан бодогч урьдчилгаа тайланг хянах ба илүү/дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт тус бүрээр гаргана” гэж заасныг зөрчсөн байна.

Дараа тооцоогоор тайлан гаргагч Адъяасүрэн Хаан, Хас банк болон кассаас авсан нийт 8 удаагийн 193.5 сая төгрөгийн зарцуулалтыг нийлүүлж 284.4 сая төгрөгөөр 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр тайлагнасан байв.

Тайланд гарсан алдаа, зөрчлүүд:

- Хас банкнаас гадаад гуйвуулгаар ZHANG CUN LIN дэлгүүрт шилжүүлсэн 6 сарын 12-ны өдрийн 350.0 мянган юань, 6 сарын 18-ны өдөр шилжүүлсэн 100.0 мянган юанийн /нийт 169,890.0 мянган төгрөг/ бэлэн бус тооцоог тайланд оруулсан.
- Мөнгөн урьдчилгааны тайланд хэдний өдөр, аль банкнаас хэдэн төгрөг авсныг тодорхой бичээгүй, бөөн дүнгээр 193.5 сая төгрөг гэж тайлагнасан
- Тайланд хэдэн ширхэг баримт хавсаргасан, баримтын нэрсийн жагсаалт үйлдээгүй
- Тайлангийн зарлагын дүн зөрүүтэй
- Тайланд хавсаргасан хятад зарлагын баримтуудыг орчуулаагүй байна.

Эдгээр нь хөрөнгө мөнгийг хяналтгүй, үр ашиггүй зарцуулах, хувьдаа ашиглах боломж нөхцөлийг бүрдүүлж байна.

2.1.3.Компаниудын тулгамдсан асуудлууд тухай бүр шийдвэрлэгдээгүй, ТУЗ-ийн хараат бус гишүүн худалдан авах үйл ажиллагаа, үр ашигт хяналт тавиагүй байна.

МУ-ын Компанийн тухай хуулиар ТУЗ нь компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах, ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаар санал боловсруулах, гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

Дээрх хуулиар компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал хийж болно, ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах гэж заасан байна.

Мөн хуулийн 77.4-т “Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх; орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих гэж ИТХ-ын эрх хэмжээг тогтоосон байна.

Байгууллагуудын ТУЗ, аймаг сумын ИТХ-аас ОНӨ ХХК, ААТҮГ, НҮГ-т чиглэсэн 2018 оны үйл ажиллагаа нь хэрхэн зохион байгуулагдсан, холбогдох хуулиудыг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг харуулбал:

Чандмань бадрал ОНӨ ХХК: Компанийн дүрэмд ТУЗ 7 гишүүнтэй байна. Эдгээрээс 1 нь хараат бус гишүүн байна гэж заажээ. Замын-Үүд сумын Засаг даргын 2017 оны А/66 дугаар захирамжаар ТУЗ-ийн гишүүдийг томилж ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан байна.

ТУЗ-ийн 2018 оны 3 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн мэргэжил, мэргэшлийн чиглэлийг харгалзан компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ажлын чиг үүргийг тусгайлан хариуцуулсан байна.

Тус байгууллагын ТУЗ 2018 онд компанийн улирлын үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангуудыг авч хэлэлцэх, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг батлах, авто машин худалдан авах, банкин дахь хадгаламжийн гэрээ цуцлах, уурын зуух худалдан авах, зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлыг дүгнэх, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны зардлыг хэлэлцэж батлах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудлуудаар хуралдаж хуралдааны тэмдэглэл хөтлөн ТУЗ-ийн тогтоол гаргаж ажилласан байна.

Тус компанийн ТУЗ-өөс ирүүлсэн шаардлагын дагуу Захирлын зөвлөл хуралдаж 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод шалгалтын хэсэг байгуулж шалгалтын дүнг 2018 оны 8 сард авч хэлэлцсэн байна.

Компанийн ТУЗ-д шалгалтын дүнг хүргүүлж ерөнхий нягтлан бодогч нь шууд удирдлага дороо ажилладаг нягтлан, эд хариуцагчидтай хэт дундаа орж шаардлага тавьж чадахгүйд хүрснээс материалын болон мөнгөн хөрөнгийн хяналт алдагдсан байна. Компанийн шаардлагад нийцсэн ур чадвартай, хариуцлагатай

хүнийг судлан компанийн санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулах хүсэлт гаргажээ.

Хуралдааны тэмдэглэлд санхүүгийн баримтуудыг үдээгүй, авто машины сэлбэгийн карт хөтлөөгүй, тоног төхөөрөмжийн картыг дутуу хөтөлсөн, бараа материалын зарцуулалтад тавих хяналт алдагдсан, зарим байгууллагаас материал авахдаа хэний ч зөвшөөрөлгүй авсан, нягтлан бодогч мөнгийг нь төлөх эсэхийг мэддэггүй, багаж хэрэгслийн бүртгэл хөтлөөгүй, материал худалдаж авахад гарсан бусад зардлыг аль өндөр үнэтэй материалд шингээж бүртгэсэн, кассын тайлан гаргадаггүй, хянадаггүй гэх зөрчлүүдийг хэлэлцсэн байв.

Чандмань бадрал ХХК 5 байршилд 14 зуухтай. Эдгээрээс 4-р зуух Замын-Үүд сумын 2 дугаар сургуулийн, 3-р зуух Замын-Үүд сумын 3 дугаар цэцэрлэгийн дансанд бүртгэлтэй байгаа нь өөр байгууллагын хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж холбогдох дүрэм журам зөрчиж байна. Иймд энэ 2 зуухыг тус байгууллагын хөрөнгөнд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх хэрэгтэй байна.

Чандмань-Илч ОНӨ ХХК: Тус компанийн дүрэмд ТУЗ 9 гишүүнтэй байна. Эдгээрээс 3 нь хараат бус гишүүн байна гэж заажээ.

Чандмань-Илч ОНӨ ХХК-ийн ТУЗ нь 2018 оны 2, 6, 12 дугаар саруудад халаалтын тоног төхөөрөмж солиход шаардагдах хөрөнгө, өвөлжилтийн бэлтгэл хангах, Мандах наран-2 хорооллын дулаан, цэвэр, бохир усны шугамын ажлыг хийхэд шаардагдах хөрөнгүүдийг банкны зээлээр шийдвэрлэх, 2019 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө батлах асуудлаар хуралджээ.

ТУЗ-өөс зээлийн эргэн төлөлт болон халаалтын тоног төхөөрөмжийг солих, шинэчлэх компанийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, зээлийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, үйлдвэрийн төлөвлөгөөт засвар, хөрөнгө, санхүүгийн ашиглалтыг тухай бүр танилцуулах, орлого нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллахыг даалгасан байна.

Эм эргэлтийн сан ОНӨ ААТҮГ: Тус байгууллагын ТУЗ 2018 оны 7 сард хуралдаж 2018 оны борлуулалтын орлогын төлөвлөгөө, төсвийн зарлагын хуваарь, бүтэц орон тоог шинэчлэн, цалин нэмж баталсан /ТУЗ-ийн 2018.07.18-ны өдрийн 01, 02 дугаар тогтоол/ байна.

Хуралдаанаар 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүү, үйл ажиллагааны тайлан, 2018 оны төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, аймгийн ЗД-ын захирамжаар тус байгууллагад ажилласан ажлын хэсгийн шалгалтын дүн, ЭЭС-ийн бүтэц орон тоо, цалин шинэчлэх, өргөдлийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай асуудлуудыг хэлэлцсэн байна.

ТУЗ-өөс санхүүгийн үйл ажиллагааг дүгнэхдээ 2017 онд борлуулалтын орлого нэмэгдсэн, ашигтай ажилласан байна. Цаашид эргэлтийн хөрөнгөө нэмэх, эмийн нэр төрлөө нэмэгдүүлэх, ажиллаж буй хүмүүсээ урамшуулах, ажлын хэсгийн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах гэсэн чиглэл өгчээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ: Тус газрын дүрэмд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дагаж мөрдөх журам, төлөвлөлт, ашиг, орлогын хуваарилалт, норм нормативыг ИТХ тогтооно, санхүүгийн тайланг жил тутамд ИТХ-аар хэлэлцүүлнэ гэж заажээ.

Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2018 оны 20 дугаар тогтоолоор Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ-ын 2018 оны бизнес төлөвлөгөөг баталж хурлын тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэл хөтөлсөн байна.

Тус газар 2018 онд 98.5 сая төгрөгийн орлоготой, 145.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд зардлын дүнгийн 50 хувь буюу 73.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал эзэлж байна.

Дүрэмдээ Бүрдэнэ сувиллын үйл ажиллагаа, хог тээвэр, сумын тохижилт, тээвэр, орон сууцны байрны үйлчилгээ, тамгын газрын буудал, цайны газар, наадмын талбай, сумын төвийн гэрэлтүүлэг, усан сан, ус түгээх цэг, газар тариалангийн үйлдвэрлэл, явган хүний зам, сумын төвийн талбай, худалдаа үйлчилгээ, гадаад худалдаа гэсэн 12 төрлийн үйлчилгээ явуулахаар заасан байна. Эдгээрээс 2018 онд амралт, сувиллын үйл ажиллагаа, халуун усны үйлчилгээ үзүүлжээ.

Гэрэлтүүлэг, хог зөөврийн машин, халуун усны барилга зэрэг нь үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байдаг бөгөөд гэрэлтүүлэг, хог зөөврийн үйлчилгээ, засварын зардал, халуун усны халаалтын зардлыг сумын ЗДТГ хариуцдаг байна.

2018 онд 83.2 сая төгрөгийн орлоготой ажилласан ба 354.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Дахин үнэлгээгээр барилга дансны хөрөнгийн үнэлгээ 281.3 сая төгрөгөөр буурсан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг нь алдагдлын хэмжээг өсгөжээ. нөлөөлсөн байна.

Сумын ИТХТ-ийн 2015 оны 17 дугаар тогтоолоор Бүрдэнэ сувиллын нэг хоногийн төлбөрийг 2-6 насны хүүхэд, 7-13 насны хүүхэд, 13-аас дээш насны сувилуулагчдын гэсэн ялгавартайгаар, мөн гэр байрны хоногийн төлбөрийг тогтоосон байна.

Сумын ИТХТ-ийн 2018 оны 05, 06 тогтоолуудаар 4.0 сая төгрөгийн 1 дүгээр хоолны тогоог актлуулах саналаа аймгийн Засаг даргад уламжлах, 0.7 сая төгрөгийн 3 нэр төрлийн хөрөнгийг актлах, 60 дугаар тогтоолоор 11 нэр төрлийн 2.9 сая төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр тус тус гаргажээ.

Мөн 2018 оны 09 дүгээр хуралдаанаар Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны тайланг авч хэлэлцсэн байна.

Замын-Үүд НААҮ ОНӨХХК: Аймгийн ИТХТ-ийн 2005 оны 20 дугаар тогтоолоор тус компанийн ТУЗ, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоосон байна. Үүнд ТУЗ-д Замын-Үүд сумын Засаг дарга, ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, Замын-Үүд сумын Засаг даргын орлогч гэж, хяналтын зөвлөлд аймгийн СЭЗБЗХ-ийн дарга, тус хэлтсийн өмчийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, эдийн засаг, төсвийн орлогын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн байна гэж тогтоожээ.

Тус байгууллагын дүрэмд үндсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлохдоо хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжийн цэвэр ус, дулааны эрчим хүчний хэрэгцээг хангах, нийтийн хог тээвэр, бохир ус зайлуулах, орон сууц, шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, шинэчлэлт хийх гэх мэт үйл ажиллагааг оруулсан байна. Гэтэл өнөөгийн байдлаар нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ

үйлчилгээ, айл өрх, албан байгууллагын хог тээвэр, гудамжны гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалт, ТӨГАҮ буюу золбин нохойг устгах, ёслол хүндэтгэлийн талбай дахь төрийн далбаа солих зэрэг үндсэн үйл ажиллагааг явуулж байна.

Мөн улсын бүртгэлийн гэрчилгээ дээр хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийг **Орон нутгийн өмчит ААТҮГ** гэж бүртгэсэн байна.

Тус байгууллагаас ТУЗ, хяналтын зөвлөлийг шинэчлэн батлуулах, дүрэмдээ өөрчлөлт оруулахаар аймгийн ИТХ, Засаг даргад удаа дараа хандсан, мөн Замын-Үүд сумын Засаг дарга, ТУЗ-ийн даргадаа компанийн дүрмийг өөрчлөх, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хариуцлагын хэлбэрийг өөрчлөх асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх, аймгийн Засаг даргад саналыг хүргүүлж шийдвэрлэж өгөхийг хүсэж албан бичиг тоот хүргүүлсэн хэдий ч өнөөг хүртэл аль ч асуудал нь шийдвэрлэгдээгүй байна.

Тус компани 76 ажилтан албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. Өөрийн дотоод үйл ажиллагааны орлогоор 22 ажилтныг сард 12.0 сая төгрөгөөр цалинжуулж ирсэн бөгөөд автобусны үйлчилгээг зогсоосон, ажилтнуудыг цалинжуулах эх үүсвэр дутаж байгаа /жилд цалин 144.0 сая төгрөг, НДШ 18.0 сая төгрөг нийт 162.0 сая төгрөг/ асуудлыг ТУЗ-д удаа дараа тавьсан хэдий ч шийдвэрлээгүй байна.

Замын-Үүд НААҮ ОНӨХХК-ийн 2018 оны бизнес төлөвлөгөөг ТУЗ 2018 оны 2 сарын 2-ны өдөр баталсан байна. Хуралдааны тэмдэглэл байхгүй байв. Хүндрэлтэй асуудлыг тухай бүр шийдвэрлүүлэх санал оруулсан ч ТУЗ хуралдаагүй байна.

Нийтлэг үйлчилгээний газар:Тус газрын зорилт, үйл ажиллагааны чиглэлийг НҮГ-ын дүрэмд аймгийн ЗДТГ-тай зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх гэрээний дагуу дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд аймгийн ИТХ, ЗДТГ-аас бодлого, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь чанартай цэвэрлэгээ, харуул хамгаалалт, тээвэр, засвар, ёслол хүндэтгэл, амрах өрөөний үйлчилгээнүүдийг үзүүлэх, аймгийн хэмжээний төрийн болон төрийн бус, ААНБ-ын захиалгын дагуу хэвлэлийн үйлчилгээ, шинээр гэр бүл болж буй хосуудын захиалгаар хуримын ёслолын үйлчилгээ, захиалгын дагуу танхимын үйлчилгээ, тоног төхөөрөмж, бичиг хэргийн материал, тавилга хэрэгслийг нийлүүлэх гэж заасан байна.

Нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр тодорхойлсон төрөл, хариуцлагын хэлбэр /нэр томьёо/ нь тус байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх хариуцлагын хэлбэр, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан төрөл, хэлбэр,Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эд хөрөнгийн эрхийн байдлаарх ангилал, Төсвийн тухай хуульд заасан төсвийн байгууллагын тодорхойлолт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан ААНБ-ын тодорхойлолттой тус тус нийцэхгүй байна. Тухайлбал:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээнд хариуцлагын хэлбэрийг “Төрийн байгууллага, албан газар, төсөвт үйлдвэрийн газар” гэж,
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ. Үүнд нөхөрлөл, компани, холбоо /төрийн

бус байгууллага/, сан, хоршоо, шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэж төрөл, хэлбэрийг заасан байна.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн байгууллага, албан газар /Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ/ төрийн өмчит үйлдвэрийн газар/аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар/ төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг гэж ангилсан байна.
4. Төсвийн тухай хуулийн 4.1.34.“төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг; 4.1.39.“төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч” гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг; гэж тодорхойлсон.
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд “аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг; гэж тодорхойлсон.

Байгууллагын хариуцлагын хэлбэрийг оновчтой тодорхойлоогүйгээс шалтгаалж аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлээр санхүүгийн тайлан гаргаж ирсэн, НӨАТ-ын тухай хуулийн дагуу татвар төлөгч байгууллагаар бүртгэгдээгүй, НӨАТ, ААНОАТ-ыг төлөөгүй явсаар ирсэн байна. Төсвийн болон үйл ажиллагааны өөрийн орлогыг төвлөрүүлэх харилцах данс нь арилжааны банкинд байршдаг тул төсвийн хуваарь, зарцуулалтад тавих хяналт алдагдсан байна.

Тус газрын дүрмийн 5.8-д “Газрын үндсэн зорилт, чиг үүрэг, санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх, хамтын шийдвэр гаргах эрх бүхий Удирдлагын зөвлөлийг газрын дэргэд ажиллуулна” гэж заасан байна.

Байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар ажиллагсдын ажлын үр дүнгээр хэдэн хувийн урамшуулал олгох тухай болон байгууллагын үйл ажиллагааны асуудлаар хэлэлцсэн байна.

ТУЗ, захирлын зөвлөлөөс байгууллагын хөрөнгө, зардлыг хэмнэх, хадгалалт хамгаалалтад тавих хяналтаа сайжруулах, үйл ажиллагаа, санхүүгийн тайланг авч хэлэлцэх тухай тогтоол, шийдвэр гаргасан хэдий ч өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргуулж аваагүй, урсгалаар явж ирсэн байна.

2.2. Худалдан авах ажиллагаанаас бий болсон ашиг, алдагдлыг тооцож тайлагнаагүй байна.

2.2.1. Санхүүгийн тайланд үйл ажиллагааны төрлөөр орлого, зарлагыг тайлагнаагүй, худалдан авах ажиллагааны үр дүнг бүртгэж тооцоогүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар дараах заалтууд байдаг байна.

- 1.Байгууллагын 3 жилийн хэтийн зорилт;
- 2.Үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ;
- 3.НББ-ийг хөтлөн явуулахад баримталсан бодлогын тухай тайлбар;
- 4.Санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг;
- 5.Төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг;
- 6.Төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт гэж заасан бол тайлагнал нь

“Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна” гэж тус тус заасан байна.

Гэтэл ОНӨ ХХК болон ААТҮГ-уудын дийлэнх нь байгууллагынхаа хэтийн зорилт, орон нутгийн төсөвт оруулах ногдол ашиг, хөрөнгө оруулалтыг тодорхой төлөвлөж тооцоогүй, тайлагнал нь зорилтын санал, төлөвлөгөөтэй харьцуулан дүгнэх боломжгүй байна. Тухайлбал: Бизнес төлөвлөгөө, жилийн төсөвтөө үйл ажиллагааны нэр төрлөөр олох орлого, зардлыг тооцсон хэдий ч жилийн эцсийн санхүүгийн тодруулга тайланд орлого, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бөөн дүнгээр тайлагнасан нь төлөвлөгөөтэй харьцуулж харах боломжгүй болгож байна.

Сангийн сайдын Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-т Орлого ба зардлыг тэдгээрийн үүсэн гарч буй шалтгаанаар нь ангилна. Орлогын зүйл анги тус бүрт зардлын зүйл ангийг зохицуулах зарчмыг баримтлан бүртгэнэ; Бизнесийн тодорхой чиглэлүүдээр зардлын зүйл ангийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, мэдээлэх ажлыг өртгийн бүртгэлийн хүрээнд зохион байгуулна гэж заасан.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээ болон үндсэн үйл ажиллагааны зардлын нэр төрлөөр нийт хэдэн төгрөгийн орлого олсон, хэдэн төгрөгийн өртөг зардал гарч, түүний ашиг алдагдал ямар байгааг тооцож гаргасан судалгаа, үнэлэлт дүгнэлтийн талаарх баримт материал зарим байгууллагуудад байхгүй, хангалтгүй байна.

Харин ЭЭС ОНӨ ААТҮГ, Чандмань бадрал ОНӨ ХХК-ууд бизнес болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үзүүлэлт тус бүрээр гаргаж тайлагнасан байна.

2.2.2. Үйлдвэрлэлийн шинэ технологийг нэвтрүүлэн өртөг зардлыг хямдруулсан хэдий ч хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалж ашигт ажиллагааны үр дүн буурчээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨ ААТҮГ нь 2018 онд Бүрдэнэ сувилалд 10.0 сая төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авч хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. Мөн

тохижилт засварын ажилд 1.9 сая төгрөг зарцуулж сувилуулагч, амрагчдын ая тухтай байдал, хүн бүрд хүртээмжтэй үйлчлэх зорилгоо биелүүлсэн байна.

Тус газар 2018 онд 83.2 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 137.8 сая төгрөгийн зардал гаргасан ба үндсэн хөрөнгийн үнэлгээ буурсан зэргээс татвар төлөхийн өмнөх алдагдал 354.5 сая төгрөг болсон байна.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК 2018 оны жилийн эцсийн байдлаар 4.6 тэр бум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна. Тайлант онд 757.9 сая төгрөгийн орлоготой, 904.9 сая төгрөгийн зардал гарган ажиллаж алдагдал 147.0 сая төгрөг байна. Зардлын дүнд хөрөнгийн элэгдлийн зардал 246.6 сая төгрөг тооцогдсон байна.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн тээврийн хэрэгсэл, техникийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн төсвөөс 24.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр дугуйт ачигчид 5.7 сая төгрөгөөр бүрэн ээлж, ковш машинуудад 6.8 сая төгрөгийн дугуй, бункер татагчид 9.1 сая төгрөгийн мотор, редуктор авч бүрэн ээлж хийсэн байна.

Тайлант хугацаанд 110.1 сая төгрөгийн 4 тээврийн хэрэгсэл тус байгууллагад нэмэгдсэнээс 29.3 мянган төгрөгийн Hyundai Starex автобусыг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор худалдан авсан байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 757.9 сая төгрөгийн орлого олж 904.9 сая төгрөгийн зардал гарган татвар төлөхийн өмнөх алдагдал 147.0 сая төгрөг байна.


Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн удирдлага санхүүгийн хүндрэлтэй асуудлуудыг даван гарах, аль болох хөрөнгө мөнгөө хэмнэх, үргүй зардал гаргахгүй байх, дотоод нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах, ажиллагсдынхаа идэвх санаачилгыг өрнүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч ажилласны үр дүнд ажилчид нь хэдийгээр бага цалинтай ч удирдлагадаа сэтгэл ханамжтай, ажлаа чин сэтгэлээсээ хийж гүйцэтгэдэг байна. Тухайлбал: 2018 онд барьсан халуун усанд ажилчид нь үргэлж ордог, хурлын зааландаа хуралддаг бөгөөд байгууллагынхаа оффиссын барилгыг өөрчлөн шинэчлэх ажилдаа ороод явж байгаа зэрэг нь бусдад үлгэр дууриалал бүхий онцлог ажил болжээ.

Чандмань бадрал ОНӨ ХХК-ийн хөрөнгө, санхүүгийн нөөц жилээс жилд өсөн нэмэгдэж ирсэн байна. 2018 онд өмнөх оноос борлуулалтын орлого 634.9 сая төгрөгөөр, эргэлтийн хөрөнгө 412.8 сая төгрөгөөр өссөн бөгөөд тайлангийн үеийн ашиг 324.5 сая төгрөг, хуримтлагдсан ашиг 1077.6 сая төгрөг болсон байна.

Чандмань бадрал ХХК давтамж хувиргуур гэсэн дэвшилтэт технологийг 2014 оноос эхлэн нэвтрүүлж эхэлсэн бөгөөд нийт цахилгаан хөдөлгүүрийн 85 хувьд давтамж хувиргуур суурилуулжээ. Ингэснээр хэт ачаалал, тэжээлийн кабель гэмтэх, механик гэмтэл гарсан үед түргэн шуурхай таслан зогсоодог тул тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлж, эрчим хүч, цахилгааны зардлыг хэмнэсэн үр дүнтэй ажил болсон байна. 2018 онд цахилгааны зардлыг 27.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Замын-Үүд сумын ус улсын дундаж стандарт зөвшөөрөгдөх хэмжээнээс 9.5-13.5 дахин их хатуулагтай байдаг тул зуухны эд анги, дулаан дамжуулах, түгээх шугамууд хэрэглэгчийн халаах хэрэгслийг зэврэлд оруулж эдэлгээний хугацааг

богиносгодог, өртөг зардал их гардаг байна. Энэ асуудлыг бууруулах зорилгоор бүх зуухнуудад ион солилцооны ус цэвэрлэх, зөөлрүүлэх аппарат ашиглаж 24 цагийн тасралтгүй ажиллах орон тоо бүрдүүлж өгчээ. Ингэснээр ажлын 5 байрыг нэмэгдүүлсэн, зуух, халаалтын шугам хоолой, халаах хэрэгсэл хагарахаа больж, айл өрх, албан байгууллагын дулааныг нэмэгдүүлсэн, өртөг зардлыг бууруулсан үр дүнтэй ажил болжээ.



Зураг1. давтамж хувиргуур



Зураг2. ус зөөлрүүлэх баллон



Зураг3. Урьдчилсан дулаалгатай хоолой

Дулааны шугам хоолойг тавьж угсрахад нүцгэн трубаны зэвийг нь арилгах, гадуур нь дулаалах, будах зэрэг хөдөлмөр зарцуулалт ордог. 2016 оноос хойш шинээр тавьж буй болон өөрчлөн шинэчилж байгаа шугам сүлжээнд урьдчилсан дулаалгатай хоолойг хэрэглэсэн байна. Урьдчилсан дулаалгатай хоолойг худалдан авч хэрэглэснээр хөдөлмөр хөнгөвчилсөн, сүлжээний насжилтыг уртасгасан, цалин, шимтгэл, материалын зардлыг хэмнэсэн байна.

Чандмань-Илч ХХК ус хангамжийг бүрэн автоматжуулж алсын удирдлагаар хянах болсон, утаа сорогчийн цахилгаан хөдөлгүүр, Зээг, Говь Дэнж гэсэн насос станцууд, гүний худаг №3-т давтамж хувиргуур суурилуулж, удирдах шит шинээр монтажилсан нь цахилгаан эрчим хүчний хэмнэлт гаргасан, 17 ус түгээх байрыг ухаалаг системээр ажиллуулах болсноор картаар цэнэглэж төлбөрт үйлчилгээ хийгдэх болсон, ус түгээх байруудад ажилладаг ус түгээгч, насос станцын машинистуудын ажлын байр байхгүй болсноор цалин, НДШ-ийн зардал хэмнэгдсэн, ус зөөврийн болон ээлж сольдог авто машины зардал байхгүй болсон байна. Мөн шөнийн цахилгаан бага үнэтэй тариф дээр ажиллах нөхцөлийг бүрдүүлж цахилгаан эрчим хүчний зардлыг бууруулсан байна.



Зураг4. Хяналт удирдлагын өрөө

1	2	3	4	5	6	7
17 870 24°C 36%	24 1690 18°C 16%	25.00°C 3.00% 24°C 36%		10 606 23°C 30%	13 692 23°C 28%	12 803 22°C 34%
Чийгшил 73%	9 15 27°C 30%	10 21 25°C 25%	11 30 16°C 18%	12 18 23°C 36%	13 19 22°C 22%	14 18 23°C 48%
2 116 16°C 53%	23 1816 18°C 58%	26 2903 23°C 39%	22 1461 22°C 46%	8 536 21°C 47%	10 917 22°C 52%	303 23389 22°C 52%

Зураг5. Хянах дэлгэц



Зураг6. Усны эх үүсвэрийн автоматжуулалт

Шатах тослох материалын зарцуулалтыг картын систем нэвтрүүлсэн, эрчим хүчний аудит хийлгэж хэмнэлтийн менежер томилон ажиллуулсан зэрэг дэвшилт ололт гарган ажиллажээ.

Чандмань бадрал ОНӨ ХХК 2019 оны 3 дугаар сард захирлын А/20 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, А/34 дүгээр тушаалаар Захиалгат бараа материалыг худалдан авахад дагаж мөрдөх журмыг баталсан байв.

Чандмань-Илч ОНӨ ХХК 2017-2018 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж авлага цуглуулалт сайжирч, өр төлбөрөө төлж, үндсэн үйл ажиллагааны орлого өссөн байгаа нь цаашид үр ашигтай ажиллах бүрэн боломжтой байгааг харуулж байна гэж дүгнэжээ.

Тус байгууллага 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өмнөх оноос мөнгөн хөрөнгө 71.3 сая төгрөг, дансны авлага 1295.8 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн үлдэх өртөг 4236.4 сая төгрөгөөр тус тус өссөн бол дансны өглөг 60.7 сая төгрөгөөр, татвар, шимтгэлийн өр 94.3 сая төгрөгөөр, банкны богино хугацаат зээл 967.5 сая төгрөгөөр, хуримтлагдсан алдагдлын хэмжээ 272.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тендерт шалгарч гүйцэтгэсэн ажлуудын санхүүжилт орж ирээгүй байгаа нь дансны авлага, банкны зээлийн өр өсөхөд нөлөөлжээ.

ЭЭС ААТҮГ 2018 онд 1319.9 сая төгрөгийн орлого олж эмийн өртөг зардал болон борлуулалтын зардал, ерөнхий удирдлагын зардалд 1318.4 сая төгрөг зарцуулж татвар төлөхийн өмнөх ашиг 1.5 сая төгрөг байна. Татварын зардал 0.1 мянган төгрөг бөгөөд 1.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

НҮГ тайлант жил 1613.6 сая төгрөгийн орлоготой ажилласнаас орон нутгийн төсвийн санхүүжилт 379.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 101.7 сая төгрөг, баяр наадмын хандив 1132.9 сая төгрөг байна. Тайлант онд 1667.9 сая төгрөгийн зардал гаргаж 54.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. 2018 онд Данзанравжаагийн мэлмий гийсний 215 жилийн ойн баяр наадмын хандивыг орлого, зарлагаар бүртгэсэн байв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аймгийн ХАА-ний төлөвлөгөөнд орон нутгийн өмчит компани, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө тусгагдаагүй байна.

Байгууллагууд ХАА-г зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуульд заасан “худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим”-ыг баримтлаагүй байна.

Шинээр барих барилгын ажлыг батлагдсан төсөвт өртөг, зураг төсөлгүй гүйцэтгэсэн байна.

Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын үр дүнд компани, байгууллагуудын зардал буурч, хэмнэлт үүссэн байна.

Ажил гүйцэтгэх гэрээнд ажлын тоо хэмжээ, нийт төсөвт өртгийг тодорхой тусгаагүй орхигдуулсан, хэрэгжилтийг тухай бүр дүгнэж ажиллаагүй байна.

Худалдан авсан сэлбэг хэрэгсэл, бараа материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түлш, шатахууны зарцуулалт болон засвар үйлчилгээг авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник ашиглалтын дэвтэрт бүртгээгүй байгаа нь тухайн техник хэрэгслийн эдэлгээний норм норматив, ажиллах хүчин чадал, ажлын гүйцэтгэл, өртөг зардал, үр дүнд тавих хяналтыг алдагдуулж байна.

Байгууллагууд үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг тайлагнасан хэдий ч санхүүгийн тодруулга тайланд үйл ажиллагааны чиглэл тус бүрээр орлого, өртөг зардал, ашиг алдагдлыг тодруулж тайлагнаагүй байна.

Худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө, бараа материал, бэлэн мөнгөний төлбөр тооцоог холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгээгүйгээс хөрөнгө шамшигдах, хувьдаа ашиглах нөхцөл бүрдэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл хууль болон дүрэмд заасан хугацаанд хуралдаагүй, хуралдааны тэмдэглэл бүрэн хөтлөөгүй, ИТХТ нь компанийн үйл ажиллагааны талаарх эрхээ хэрэгжүүлээгүй, компанийн үйл ажиллагааг тодорхойлж чиглүүлээгүй, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт хяналт тавих үндсэн чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Тухайн жилийн тендерт шалгарсан ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж, санхүүжилтээ аваагүй байгаа нь мөнгөн хөрөнгийн эргэцийг удаашруулж, ашигт ажиллагааг бууруулж байна.

Орон нутгийн өмчит ХХК-иуд шинэ дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж өртөг зардлаа хэмнэн, үр ашгаа дээшлүүлсэн ололттой тал байгаа хэдий ч хөрөнгө, материал бэлтгэх үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тодорхой бүртгэж, тайлагнах, холбогдох журам, стандартыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Аудитаар нийт 3637.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 19.8 төгрөгийн 1 төлбөрийн акт, барилгыг ашиглалтад оруулах 1 албан шаардлага бичиж, 1195.6 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж, 2421.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН ДАРГА НАРТ

- Нийтлэг үйлчилгээний газрын хариуцлагын хэлбэрийг хууль эрх зүйд нийцүүлж оновчтой тодорхойлж, чиглүүлэх
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан компанийн үйл ажиллагааны талаарх эрхээ хэрэгжүүлж ажиллах
- Байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт тавих хяналтыг сайжруулах

ТУЗ-ИЙН ДАРГА НАРТ

- Чандмань-Илч ХХК-ний дүрэмд Гүйцэтгэх захирал компанийн үйлдвэрлэл, төсөв төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр батлуулах, биелэлтийг хангах, тайлагнах, мөн хөдөлмөрийн дотоод журам боловсруулж батлуулах зэрэг эрх үүргийг нэмж тусгуулах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, гишүүдийн хурлыг хуралдуулах, тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах

ОНӨ ААНБ-ЫН ЗАХИРАЛ, ДАРГА НАРТ

- ХАА-г зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуульд заасан “худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчим”-ыг баримталж ажиллах
- Ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах
- Авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, техник ашиглалтын дэвтрийн үзүүлэлтүүдийг бүрэн хөтлөх
- Санхүүгийн тодруулга тайланд үйл ажиллагааны чиглэл тус бүрээр орлого, өртөг зардал, ашиг алдагдлыг тодруулж тайлагнаж байх
- Худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө, бараа материал, бэлэн мөнгөний төлбөр тооцоог холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэх, хяналтаа сайжруулж хөрөнгө шамшигдах, хувьдаа ашиглах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх.
- Тендерээр гүйцэтгэсэн ажлыг комисст хүлээлгэн өгч, санхүүжилтийн авлагаа барагдуулах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА



**“ЧАНДМАНЬ-БАДРАЛ” ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

44013 Дорноговь аймаг, Замын-Үүд сум, Борхойн тал,
УБД: 0611005052, Утас: 96016946,
E-mail: Chandmanibadral@yahoo.com

2019.09.09 № 1/279
танай _____ ны № _____ т

“ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ”

Тайлбар хүргүүлэх тухай

1036,992 төгрөгийн жагсаалтаар гарсан албан шаардлагын хувьд:

1. Тус байгууллага нь орон нутгийн онцгой объект буюу өвлийн улиралд ус дулаанаар оршин суугчдыг тасралтгүй хангах мэргэжлийн байгууллагын хувьд хүлээсэн үүргийнхээ дагуу цаг үед нь гарсан гэмтлийг 6 цагаас дээшгүй хугацаанд арилгаж хэвийн ажиллагааг хангаж ажиллах зайлшгүй шаардлагын дагуу гарсан гэнэтийн буюу тодорхойгүй зардлыг гаргаж ажилласан болно.

2. Мөн 2018 онд Дорноговь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэсээс зарласан “Ургах наран” 284 айлын орон сууц бүхий 5 блок ажил, 500 хүний суудалтай “Соёл спорт” цогцолборын тендерт оролцон ялж гүйцэтгэсэн шугмын ажилд шаардагдсан 313093000 төгрөгийн материалыг татан авахад зарцуулсан мөнгийг худалдан авах ажиллагааны хууль зөрчсөн гэж үзсэнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм Учир нь :

Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэх хугацаа нь гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу 2 сарын хугацаанд хийж дуусгах ёстой ба тендерт ялаад дахин тендер зарлах хугацааны хувьд ямар ч боломжгүй.

Хэрэв тендерт ялаад дахин тендер зарлах ёстой юм бол захиалагчаас энэ хугацааг болон бусад шаардлагуудыг тендерийн бичиг баримтанд тодорхой зааж оруулж өгөх байсан. Ийм шаардлага тавиагүй учраас хилийн ойр байдаг өөрийн компанийн давуу талыг ашиглан аль нэг гадны гуравдагч компанийг оролцуулалгүйгээр хамгийн хямд үнэтэй материалыг худалдан авсан тул уг худалдан авалтыг хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна.

3. Мөн Засвар үйлчилгээний зардалд 12,000.000 төгрөгийн бараа материал 64,240.000 төгрөгийн хангамжын материалууд, худалдан авч зарцуулсан нь бүтэн жилийн хугацаанд гарсан гэмтлүүдийн сэлбэг хэрэгсэл болон шугам сүлжээнд зарцуулсан зардал бөгөөд гарах гэмтлийг урьдчилан харах боломжгүй тул 1 сараас 12 сар хүртэл нийт зарцуулсан хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу тухай цаг үед нь дээрх босго үнийг даваагүй тул хууль зөрчөөгүй болно.

4. Гадаад үйлчилгээнд зардалд тусгагдсан 17,940.000 төгрөгийн зарцуулалтанд байгууллагын интернет үйлчилгээний зардал, санхүүгийн програмын жил улирлын татварууд, аудитын төлбөр, тээврийн хэрэгслийн оношилгоо, даавгал, татвар зэрэг багтсан нь худалдан авах ажиллагааны хуулиар зохицуулах босго үнэ биш болно.

5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зардалд 35,544.000 төгрөг зарцуулсан нь нэг төрлийн ажил үйлчилгээ материал биш бөгөөд ОНӨХАҮХА -ны хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д зааснаар бараа ажил үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан ижил төстэй байдлаар нь багцад хувааж тендер явуулж болно гэж заасан нь заавал зарлах ёстой гэсэн утга агуулаагүй тул бүтэн жилийн туршид хэрэглэсэн багаж хэрэгсэл, сургалт, хор саармагжуулахад болон эмчийн үзлэгт зарцуулсан өөр өөр ажил үйлчилгээтэй холбоотой учир худалдан авах ажиллагааг зөрчсөн гэж үзсэнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

5. Манай компанийн хувьд нүүрсийг зөвхөн “Шивээ овоо” компаниас гэрээгээр авдаг бөгөөд бусад компанийн нүүрс нь манай шаардлагад нийцдэггүй болно. Хэрэв заавал тендер зарлах ёстой гэж хуулиар заасныг биелүүлэх ёстой гэж үзвэл дүр үзүүлсэн, хугацаа алдсан байдалтай тендер зарлах болж байгаа нь хүндрэлтэй байгааг хэлэх нь зүйтэй болов уу. Ялангуяа олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг онцгой объектын хувьд бусад төсвийн газруудтай адилтган үзэхгүйгээр зөвхөн ганц газраас нийлүүлдэг нүүрсийг онцгойлон үзэх шаардлагатай гэж үзэж байна. Гарч байгаа нэг хүндрэл нь “Шивээ овоо” ХХК -нь танайх тендер зарласан байна. Бид оролцох шаардлагагүй, бусад нүүрсний компаниас сонголтоо хийгээд үз гэвэл дараагийн асуудлыг нь яаж шийдэх вэ? гэсэн асуудал тулгарна. Гэвч 2019 оны тендер зарлах төлөвлөгөөнд нүүрсийг оруулсан болно.

6. Шатахуунд зарцуулсан 55,021.000 төгрөгт тавигдсан албан шаардлагыг үндэслэлтэй гэж үзэж байгаа тул 2019 онд зарлах тендерийн төлөвлөгөөнд оруулан батлуулан ажиллаж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



У.САНРАЙЖАВ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ДОРНОГОВЬ АЙМАГ
“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИ

44105 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Утас/факс: (705) 2-23-08

2019.07. № 342
танай 2019.07.03 ны № 16/1997 Т

Аудитын тайланд санал
хүргүүлэх тухай

Чандмань-Илч ХХК нь 2017 онд Ус түгээх байруудыг автоматжуулах, ухаалаг цахим худгийн ажлыг эхлүүлж Ус сувгийн удирдах газарт цахим худаг нэвтрүүлсэн НТЛ ХХК болон цахим худгийн тоног төхөөрөмж программ хангамж нийлүүлдэг Баялаг говь ХХК-иудаас үнийн санал авч, газар дээр нь туршлага судалсны үндсэн дээр Баялаг говь ХХК-иас 1 сервер, 2 цахим худгийн тоног төхөөрөмж авч суурилуулан 2017-2018 онд туршсан. Туршилтын хугацаанд ямар нэгэн гэмтэл, хэрэглэгчдээс гомдол санал гараагүй тул 2018 онд 14 худгийг гэрээ байгуулан 119,0 сая төгрөгөөр худалдаж авсан. Айраг сумын Ус түгээх байрыг цахимжуулах тендэрт манай компани шалгарч дахин нэг худгийг цахимжуулсан. Тухайн сервер нь өөр компанийн угсарсан цахим худгийг таних боломжгүй тул 2018 оны худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулан худалдан авсан болно.

Чандмань-Илч ХХК-ийн дүрмийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлийн 2019 оны 30 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Ингэхдээ компанийн ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлсэн болно. Хурлийн тэмдэглэлийг ТУЗ-ын дарга болон нарийн бичгийн даргын архивын баримтаас шалгана уу. Хөдөлмөр хамгааллын өвлийн хувцас нийлүүлэх тендер зарлаж тендэрт шалгарсан Болор ирээдүй ХХК-тай гэрээ байгуулж бараа ажил үйлчилгээг хүлээн авсан. Аудитын тайланд 2018 онд 35,2 сая төгрөгийн хувцас гутал нийлүүлж гэрээний үнээс 18,9 сая төгрөгийг илүү олгосон гэжээ. Гэтэл 2 өөр ажил төрлийн бараа ажил үйлчилгээ буюу өвлийн хувцасны болон гутлын гэрээг нийтэд дүгнэсэн алдаа дутагдал гарчээ.

Чандмань-Илч ХХК нь 2018 онд Улсын болон Орон нутгийн 1577,5 сая төгрөгийн тендерийн ажил гүйцэтгэж тендерүүдэд болон үндсэн үйл ажиллагаанд БНХАУ-аас 1011,9 сая төгрөгийн бараа материалыг худалдаж авчээ. Тендерийн ажил нь графикт хугацаатай тул тендерийн бараа материалыг худалдан авахдаа ХАА-ны тухай хуулийг баримтлах боломжгүй юм. Харин үйл ажиллагаандаа худалдаж авсан бараа материал нь үнэ, нэр төрлийн хувьд босго үнээс даваагүй болно. Бид санхүүгийн анхан шатны баримтыг аудитын тайлантай тулган үзэхэд бүртгэл болон анхан шатны баримтууд алдаа зөрчилгүй, ойлгомжтой, орчуулга хийгдсэн, жилийн эцэст өр авлагын тооцоо нийлсэн, зээлээр бараа материал худалдан авах үедээ гэрээ байгуулсан баримтууд байсаар байтал аудитын тайланд энэ талаар буруу, зөрүүтэй бичсэн байна.

4421900030

Мөн компанид бэлэн мөнгөний дутагдалтай улмаас бараа материалыг зээлээр худалдан авах, шилжүүлсэн мөнгөөс өмнөх худалдан авсан барааны өр төлж үлдсэнээр нь бараа худалдан авч дахин зээл тавих гэх мэт санхүүгийн арга хэлбэрүүдийг ашиглаж ирдэг нь аудиторуудын шалгалт хийх явцыг хүндрүүлэх, буруу зөрүү ойлголт бий болох, улмаар хардалт сэрдэлт төрүүлсэн байж болзошгүй тул сайтар нягтлан Аудитын тайланд зөв залруулж өгнө үү.

ЗАХИРАЛ



Т. АЗБАЯР

D:/A4/doc



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/20

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр 19.3.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, 2018 оны А/207 тоот тушаалын 5-р хавсралтын 2.4 дэх тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн өмчит ХХК-ийн худалдан авах ажиллагааны үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, 01/88 ДГА-2019/27/ГА тоот албан шаардлага, 01/71 ДГА-2019/27/ГА тоот төлбөрийн актыг тус тус баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг Аймгийн ИТХ, Замын-Үүд сумын ИТХ-ын дарга, Чандмань Илч ХХК, Чандмань Бадрал ХХК, Эм эргэлтийн сан АТҮГ, Дагшин-Эрдэнэ АТҮГ, Замын-Үүд НААҮ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, захирал нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, Нийтлэг үйлчлэгээний газрын дарга, Чандмань Илч ХХК, Эм эргэлтийн сан АТҮГ, Дагшин-Эрдэнэ АТҮГ, Чандмань Бадрал ХХК, Замын-Үүд НААҮ ХХК-ийн захирал нарт хүргүүлсүгэй.
4. Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Энхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

1. Чандмань бадрал ОНӨ ХХК-иас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

- Аудитын тайлангийн дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой санал ирүүлээгүй тул аудитын тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Ирүүлсэн санал нь тус байгууллагын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитын хариу байна.

2. Чандмань-Илч ОНӨХХК-иас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

- Аудитын тайлангийн 1.1.2-т ирүүлсэн тайлбар нь баримтаар нотлогдоогүй, 1.2.1-д ирүүлсэн тайлбар нь нэмэлт тайлбар учир тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
- Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбарын 3, 4 дэх хэсэгтэй холбогдох асуудлыг аудитын тайлангийн 2.2 хэсэгт өөрчилж орууллаа.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

Ц.Лүндэгмаа

Аудитор

П.Энхбаяр

ХЯНАСАН:

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Энхцэцэг

2019 оны 7 сар